


Барилга, хот байгуулалтын сайдын  
2019 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн  
34 тоот тушаалын гуравдугаар хавсралт



**ХОТ ТОСГОН, БУСАД СУУРИНЫ ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧАНАРЫН  
УЛСЫН ХЯНАН БАТАЛГААНЫ АЖЛЫН АРГАЧИЛСАН ЗААВАР**

Гарчиг	
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
Ажлын үе шат ба ажилбарууд	4
НЭГ.БЭЛТГЭЛ АЖИЛ	6
1.1.Мэдээлэл цуглуулах	6
1.2.Нэгж талбар	9
1.3.Агаар, сансрын болон дроноор авсан зураг ашиглах	10
1.4.Ажлын зураг	10
1.5. Мониторингийн цэг	11
1.6.Бичиглэлийн цэг	12
1.7. Хөрсний судалгаа	12
1.8.Бэлтгэл ажлын тайлангийн агуулга	16
1.9.Бэлтгэл ажлын захиалагчийн хяналт	17
ХОЁР.ХЭЭРИЙН СУДАЛГАА	18
2.1.Ярилцлагын судалгаа	18
2.2.Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох	19
2.3.Газрын гадаргын төрх байдал (хөрсний зулгаралт, элэгдэл, эвдрэл)	20
2.4. Ногоон байгууламж ба хог ургамлын тархалт	20
2.5.Хөрсний механик бүрэлдэхүүн	21
2.6.Хөрсний РН	21
2.7.Хөрсний ялзмагт үеийн зузаан	21
2.8.Хөрсний ялзмагийн агууламж	21
2.9.Хөрсний бохирдол	21
2.10.Хөрсний хүнд металлын бохирдол	22
2.11. Усны шинжилгээний дээж авах	23
2.12.ХАА-н үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулагдсан бусад газрын бохирдол	26
2.13.Зам, шугам сүлжээний газрын бохирдол	26
2.14.Нийтийн эдэлбэрийн газрын бохирдол	26
2.15.Хээрийн ажлын тайлангийн агуулга	26

2.16.Хээрийн ажлын захиалагчийн хяналт .....	27
3.МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ .....	27
3.1.Үндсэн үзүүлэлт .....	27
3.2.Хянан баталгааны үндсэн мэдээллийг боловсруулах нь.....	28
3.3.Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулах.....	31
3.4.Мониторингийн цэгийн хувийн хэрэг бүрдүүлэх .....	31
3.5.Хянан баталгааны дүгнэлт бичих.....	31
3.6.Хянан баталгааны акт бичих: .....	31
3.7. Нэгж талбарын сүлжээний зураг боловсруулах.....	32
3.7.1.Зураглах.....	32
3.7.2.Хүснэгтэн мэдээлэл оруулах .....	33
3.7.3.Зургийн эх бэлтгэх.....	33
3.7.4.Зураг хэвлэх .....	35
3.8.Хянан баталгааны ажлын тайлан.....	35
Тайлан бичих.....	35
Тоон файлыг хуулбарлах .....	38
3.9.Ажлын үр дүнг шалгах, хүлээн авах.....	39

Хавсралтууд:

Хавсралт 1. Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа ба өнгөний код

Хавсралт 2. Геоботаникийн бичиглэлийн маягт

Хавсралт 3. Ургамлын бичиглэлийн маягт

Хавсралт 4. Монгол орны хөрсний нэршил ба код

Хавсралт 5. Хөрсний код бичих зааварчилгаа

Хавсралт 6. Хөрсний бичиглэлийн маягт

Хавсралт 7. Хөрсний маршрутын судалгааны бичиглэл

Хавсралт 8. Мониторингийн цэгийн хувийн хэрэг

Хавсралт 9. Хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт

Хавсралт 10. Үр дүнг харьцуулах

Хавсралт 11. Ажлын даалгаварын загвар=

Хавсралт 12. Ажлын даалгавар бичих заавар

Хавсралт 13. Баталгааны хуудасны загвар

Хавсралт 14. Шаардлагатай стандартууд

1. Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код

- a. MNS5641-0-2006 2х,
  - b. MNS5641-1-2006 6х,
  - c. MNS5641-2-2006 34х,
  - d. MNS5641-3-2006 47х
2. Хөрс.Хөрсний агро-химийн үзүүлэлтийг тодорхойлох. MNS 3310:1991.
  3. Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд -MNS3298-1991
  4. Хөрсний нийт азот тодорхойлох арга MNS3242-1989
  5. Хөрс.Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS4006-1987
  6. Хөрсний чанар. рН тодорхойлох MNSISO10390-2001
  7. Байгаль орчны бохирдол, бохирдлын хяналт ба хамгаалалт - Агаар, хөрсөн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 6147:2010
  8. Ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр төрөл. MNS3985-87
  9. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2008
  10. Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000. MNS 6702:2017
  11. Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:25000, 1:50000, 1:100000. MNS 6703:2017
  12. Усны орчин тодорхойлох MNS ISO 10523:2001
  13. Усны цахилгаан дамжуулах чанар MNS ISO 4889:1999
  14. Усны өнгө тодорхойлох MNS ISO7887:2000
  15. Усны булингар тодорхойлох MNS ISO 1097:1970
  16. Хатуулаг MNS ISO 6059:2001
  17. Нянгийн ерөнхий тоо тодорхойлох MNS 5668-2006
  18. Энтерококкийн таньц тодорхойлох MNS 5668-2006
  19. Гэдэсний бүлгийн нян /коли-титр, коли-индекс/ тодорхойлох MNS 5668-2006
  20. Гэдэсний бүлгийн эмгэгтөрөгч нян тодорхойлох MNS 5668-2007
  21. Клостридум перфрингенс тодорхойлох MNS 5668-2008

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Газрын тухай хуульд заасны дагуу газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа нь газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаанд төрийн хяналтыг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор газрын төлөв байдал, чанарын тогтвортой, гол үзүүлэлтүүдийг хууль тогтоомжид заасан хугацаанд давтан тодорхойлж улсын хяналтад авсан анхны үзүүлэлтүүдтэй харьцуулан дүгнэлт гаргахад оршино.
2. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж, дүгнэлт гаргах бөгөөд газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газрыг 5 жилд нэг удаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаанд заавал хамруулж байхаар заасан байдаг.
3. Хот тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын зорилго нь хот суурин газрын хөрс, ургамлын төлөв байдал, чанарыг тодорхой үзүүлэлтүүдээр гаргаж, төлөв байдал, чанарт гарсан өөрчлөлтийг тодорхойлж, зураглан, дүгнэлт гаргах явдал юм.
4. Энэ аргачилсан зааврын зорилго нь хот тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг гүйцэтгэх, гүйцэтгэлд хяналт тавих, газрын төлөв байдал, чанарт гарсан өөрчлөлтийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, тайлан бичиж дүгнэлт, зөвлөмж боловсруулах, хянан баталгааны мэдээллийн сан байгуулах ажлыг нэгдсэн аргачлалаар хангахад оршино.
5. Газрын хянан баталгааны ажил шинжээчээс мэргэжлийн өндөр ур чадвар, өргөн хүрээтэй үйл ажиллагаа шаардана. Газар дээр хийсэн ажиглалт хэмжилт, дээж авах газар бодит байдлыг баттай төлөөлөх буюу газар ашиглалтын өнөөгийн байдалд зөв үнэлэлт дүгнэлт өгөхөд оршино.
6. Хот тосгон, бусад суурин газрын хянан баталгаа хийх, талбайн ажлын үед анхаарах асуудал бол тухайн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил газрын ашиглалт нь зөвхөн тэр орчиндоо төдийгүй томоохон хэмжээнд бусдад дам үйлчилдэгт оршино.
7. Хот тосгон, бусад суурин газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг 3 үе шаттай гүйцэтгэх бөгөөд бэлтгэл, хээрийн судалгаа, материал боловсруулалтын үе шатуудаас бүрдэнэ. Ажлын үе шат, хийх ажилбаруудыг дараах хүснэгтээр тойм байдлаар үзүүлэв.

### Ажлын үе шат ба ажилбарууд

Хүснэгт 1

Бэлтгэл ажлын үе шат	
1. Мэдээллийг цуглуулах, боловсруулах	
1	Хянан баталгаа хийх газрын орчны газарзүйн нөхцөл, байгаль орчны төлөв байдлын судалгааны мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх

2	Газрын хөрс, ургамлан нөмрөг, гадаргын болон гүний усны горимын цэгчилсэн судалгааны үр дүнг цуглуулан байршил, солбицолоор бүртгэлжүүлэх
3	Газрын кадастрын зураг, мэдээллийн санд үндэслэн газрын зориулалт, байршил, хэмжээ, эрх зүйн талаар судлах
4	Өмнө хийгдсэн хянан баталгааны тайлан, паспорт болон материалыг судлах, харьцуулан дүгнэлт хийх зорилгоор холбогдох газраас материалыг хувиран авах
<b>Хээрийн судалгааны зураг зохиох</b>	
1	Тоон байр зүйн зургийг бэлтгэх
2	Газрын кадастрын зургийг байр зүйн зурагтай давхцуулах
3	Агаар, сансрын зургаас газрын гадаргын механик өөрчлөлт, хөрс-ургамлан нөмрөгийн төлөв байдлыг тодруулан, ажлын зурагтай давхцуулан өөрчлөлтийн хил заагийг тогтоох
4	Өмнөх хянан баталгааны тайлан, зургаас хөрсний тархалтын хил заагаар үүсгэсэн экологийн нэгж талбарын байр зүйн ситуацад нийцсэн байдлыг тодотгох, хөрсний нэр, индексийг түүвэрлэх
5	Зурагт төлөв байдлын өөрчлөлтөд орсон болон өөрчлөлт оруулж болох хүчин зүйлс бүхий газрыг байршлаар нь ажлын зурагт оруулах
6	Хог ургамал, бохирдлын мэдээллийг холбогдох газруудаас авч байршлаар нь ажлын зурагт оруулах
7	Өмнөх зурагт тэмдэглэгдсэн мониторингийн цэгүүдийг ажлын зурагт оруулах
<b>Удирдлага-зохион байгуулалтын ажил</b>	
1	Хээрийн судалгааны эх зургийг үндэслэн тодруулалтын судалгааны удирдамж боловсруулан зөвлөгөө, заавар, аргачлалаар хангах;
2	Хээрийн судалгаанд шаардлагатай багаж хэрэгсэл, программ хангамж, унаа, мониторингийн цэг байгуулах болон бусад шаардлагатай материал эд зүйлсийг бэлтгэх
<b>Хээрийн судалгаа</b>	
1	Газрын гадаргын төлөв байдал, гадаргын механик бохирдлын хүрээ хязгаарыг тогтоон зурагт оруулах
2	Газар ашиглалтын аюулгүй байдал, байгаль орчинд сөрөг нөлөөлөх үзүүлэлтийг судлан тогтоох
3	Хөрсний зулгаралт, элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлтийн байдлыг тодорхойлон ажлын зурагтай тулган нарийвчлах, ялгарал бүрээс дээж авах
4	Хөрсний хими, физикийн бохирдлын эх үүсвэр байршлыг тогтоон дээж авах
5	Хөрсний биологийн бохирдлын эх үүсвэр илрэлийн хэмжээг тогтоон дээж авах
6	Гадаргын болон гүний усны дээж авч шинжлэх

7	Хог хаягдлаар бохирдсон газрын байршлыг тогтоох
8	Мониторингийн цэг тогтоох
9	Газрын төлөв, байдал чанарын хянан баталгааны дүгнэлтийг газар дээр нь бөглөх
Материал боловсруулалт	
1	Хөрсний агрохимийн, химийн элемент, бохирдлын шинжилгээ хийх
2	Судалгаагаар тодорхойлогдсон газрын төлөв байдал, чанар, нөлөөллийн бүх үзүүлэлтийг кодлон, ажлын зурагтай холбон, мэдээллийн сан үүсгэж, хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг, хянан баталгааны дэлгэрэнгүй ба товчоо хүснэгтийг эцэслэн боловсруулах
3	Хянан баталгааны нэгж талбар бүрийн дүгнэлтийг эцэслэн боловсруулах
4	Эзэмшил, ашиглалт, өмчлөлийн газрыг ашиглалтын зориулалтаар нь ангилан газрын нэгдмэл сангийн ангиллын дагуу экспликаци гаргах
5	Хянан баталгааны үзүүлэлт бүрийг өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах
6	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан бичих, дүгнэлт гаргах
Ажлыг хянуулах, хүлээлгэн өгөх	
1	Хянан баталгааны ажлыг захиалагч байгууллагад шалгуулах
2	Захиалагчаас өгсөн шүүмжийн дагуу засварыг хийх
3	Захиалагч байгууллагын хурлаар хэлэлцүүлж дүгнэлт гаргуулах
4	Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг, тайлан дүгнэлт хэвлэх, хүлээлгэн өгөх

## НЭГ.БЭЛТГЭЛ АЖИЛ

### 1.1.Мэдээлэл цуглуулах


1. Хот, суурин газрын ус, агаар, хөрсний бохирдол, түүний эх үүсвэр болон бохирдлыг бууруулах, экологийн эрүүл орчин бүрдүүлэх талаар төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, эдгээртэй холбоотой хууль, дүрэм, тогтоол, шийдвэр, бодлого, хөтөлбөрүүдтэй сайтар танилцаж, дүн шинжилгээ хийнэ.
2. Аймаг, орон нутгийн зүгээс болон бусад төрийн болон төрийн бус байгууллагын санаачлагаар хот суурин газрыг бохирдлоос хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлсэн эсэх, бохирдсон газрын тооллого бүртгэл явуулсан эсэх, газар ашиглалт, хамгаалалтын талаар авч хэрэгжүүлсэн бодлого, хөтөлбөрийн талаар судлана.
3. Албан байгууллага, үйлдвэрийн газрын үйл ажиллагааны онцлог, хөрс, ургамлан нөмрөг, гадаргын болон гүний усны горимын талаар судалж, газарт учруулах хохирол, экологид нөлөөлөх талаас нь бодитой мэдээ материал цуглуулна.

Эдгээрээс гадна газар дээр явуулж буй үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн онцлогтой холбоотой ялангуяа хэрэглэгдэх химийн бодис, үйлдвэрлэлийн явцад ялгарч болзошгүй хорт бодис, бохирын системийн тухай ойлголт мэдээлэлтэй болох шаардлагатай.

4. Газрын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн, газрын даамал, мэргэжлийн хүмүүсийн санал, зөвлөгөөг авч, хөрс, усны бохирдол үүсгэж байгаа, үүсгэх магадлалтай байршлыг урьдчилан ажлын зурагт тодорхойлно.
5. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэл, үйл ажиллагааны онцлогийг судалж үнэлэлт дүгнэлт өгнө. Ялангуяа газар ашиглаж ирсэн онцлог, түүний экологит нөлөөлөх онцлогийг урьдчилан мэдэрч, таамаглал дэвшүүлэх үндсэн дээр хээрийн судалгааны хэмжилт, чиглэлийг тогтооно.
6. Хот суурин газрын 0 гортигийг газрын нэгдмэл сангийн тооллогод тусгагдсан хил зааг, газрын кадастрын мэдээллийн санд байгаа хил заагийг ажлын зурагт оруулна.
7. Мөн газрын кадастрын мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газрын кадастрын тоон зургийг бэлтгэж, ажлын зурагт оруулна.
8. Хотын хөгжлийн төлөвлөгөөний зураг, 1:1000 масштабтай байр зүйн зураг, кадастрын зураг, агаар, сансрын зураг нь тухайн суурин газрын нарийн мэдээлэл өгөх тул хянан баталгааны суурь материал болгон ашиглана.
9. Агаар, сансрын зураг, газар ашиглалт, хөрс ургамлын зураглал, газрын нэгдмэл сангийн бүртгэл зэргийг үндэслэн хянан баталгааны нэгж талбарын тоо, талбайн хэмжээг тодорхойлно.
10. Агаар, сансрын зураг ашиглан шинээр үүссэн суурьшил, нийт сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд үүссэн суурин газруудыг тодотгож ажлын зурагт зураглана. Жишээ нь уул уурхай дагасан суурин, улсын чанартай автозам дагуу суурин газар, амралт, сувилалын газар дагасан суурин, бусад г.м.
11. Мөн газрын кадастрын зураглал хийгдээгүй, шинээр үүссэн нэгж талбар, газар ашиглалт, хөрсний элэгдэл эвдрэл, ургамлан нөмрөгийн бүрхэц, ногоон байгууламж, үер ус буух магадлалтай газар, гуу жалга үүссэн газар, хогийн цэгийн байршил, зохиомол хогийн цэг, хог ургамал болон хөрсөн бүрхэвчийн өөрчлөлт, элс хуримтлагдсан газар, усны эвдрэлд орсон газар, авто зам үүссэн газар, худаг уст цэгийн байршил, гадаргын ус зэрэг мэдээллийг авч ажлын зурагт тэмдэглэнэ.
12. Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг газрын кадастрын зурагтай давхцуулж, төлөвлөгөөний дагуу баригдах болон одоогийн барилга, байшингийн байршлыг ажлын зурагт оруулна.
13. Газар эзэмшигч, ашиглагч аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрийн газар, айл өрх, иргэдийн эзэмшиж байгаа газрын байршил, нийтийн эдэлбэрийн газар, гэр хорооллын газар, зам, гудамж, хатуу хучилттай талбай, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж гэх зэргээр ангилан ажлын зурагт оруулна.
14. Өмнө хийгдсэн хянан баталгааны ажлын тайлан, зурагт дүн шинжилгээ хийж, хянан баталгааны зургийг шинэ солбицолын системд шилжүүлэх, өмнө нь дээж

авсан цэг болон нэгж талбарыг одоогийн газар ашиглалтын байдалтай тулгах, нэмэлт нэгж талбаруудыг тогтоох, хуваагдах, өөрчлөгдөх нэгж талбаруудыг тодорхойлно.

15. Цуглуулсан баримт материалд дүн шинжилгээ хийж, хээрийн тодруулалт судалгаа хийх удирдамж, төлөвлөгөө, маршрутыг боловсруулж ажлын зурагт тэмдэглэнэ.
16. Бэлтгэл ажлын хүрээнд хөрс, ургамлын зураг, газар ашиглалтын төрөл, нягтаршлыг харгалзан бичиглэл, дээж авах цэг, мониторингийн (хяналтын) цэгийг урьдчилан төлөвлөх бөгөөд цэгийн байршил, солбицолыг ажлын зурагт оруулна.
17. Хээрийн ажил гүйцэтгэх багийг бүрдүүлж, томилолт, унаа, зөвлөгөө, удирдамжаар хангах бөгөөд хээрийн судалгаа хийх маршрутыг ажлын зурагт оруулсан байна.
18. Хянан баталгааны ажилд аймгийн газрын асуудал эрхэлсэн байгууллагын мэргэжилтэн, сумын газрын даамлыг заавал оролцуулах тул гүйцэтгэгч хээрийн судалгаа эхлэхээс өмнө холбогдох газарт мэдэгдэж, оролцох мэргэжилтэн, албан тушаалтныг томилуулсан байна.
19. Хээрийн судалгаанд ашиглах ажлын зураг, 100x100 см-ийн тор, модон гадас, хүрз, өрөм, метр, шугам, жин, рулет, гадас, 20-30 м урттай цагаан утас, солбицлыг тодорхойлох GPS, бичиглэлийн маягт, фото аппарат, цагаан самбар, цагаан самбарын арилдаг бал, хөрсний дээжний уут, усны дээжний сав, дээжний хаяг бичих маягт, балын харандаа болон бусад шаардагдах багаж хэрэгслийг бэлтгэнэ.



Зураг 1. Цагаан самбар ашиглах жишээ /зурагт цаад талбай харагдахаар байна/ Самбарт дараах мэдээллийг дэс дараалуулж бичнэ.

1. Аймгийн нэр
  2. Сумын нэр
  3. Цэгийн төрөл /бичиглэлийн, мониторингийн, дээж авсан/
  4. Цэгийн дугаар
  5. Солбицол
  6. Он сар өдөр
20. Хээрийн ажлын удирдамж, төлөвлөгөө, бэлтгэл ажлын тайланг боловсруулж захиалагчид хүргүүлж, ажил шалгасан дүгнэлт гарсаны дараа хээрийн судалгааны ажлыг эхлүүлнэ.



## 1.2.Нэгж талбар

Хянан баталгааны ажлыг хянан баталгааны нэгж талбарт тулгуурлаж гүйцэтгэх бөгөөд нэгж талбарыг дараах зарчмаар хуваана. Үүнд:

- Экологийн буюу үндсэн нэгж талбар (газрын гадарга, хөрс, ургамлан нөмрөг)
- Газар ашиглалт (гэр хороолол, барилга байгууламж, худалдаа үйлчилгээ ...)

**Үндсэн нэгж талбар:** Экологийн буюу үндсэн нэгж талбар гэсэн ойлголтонд хөрсний тархалт, ургамлан нөмрөг, газрын гадарга буюу уул, хөндий, голын хөндий зэрэг газрын гадарга, хөрс, ургамлын онцлогыг харгалзана.

**Дэд нэгж талбар:** Үндсэн нэгж талбарыг газар ашиглалтын зориулалтаар хуваасныг дэд нэгж талбар гэнэ. Өөрөөр хэлбэл барилгажсан, хатуу хучилттай, автозамын дагуу, төв гудамж, гэр хороолол, худаг, уст цэгийн орчим, хог хаягдлын цэг орчим, уурын зуух, шатахуун түгээх станц, ногоон байгууламж зэргээр хуваагдана.

Дэд нэгж талбарын хил заагийг газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлийн хил зааг, төв зам, гудамж, багийн хил зэрэг тодорхой хил заагаар тогтоож болно.

Тухайн суурин газрын 0 гортигоос гадна байрлаж байгаа газар ашиглалтыг газрын кадастрын зургийг үндэслэн мөн дэд нэгж талбар болгоно.

Дэд нэгж талбар бүрээс хөрс, ургамлын дээж авч, бичиглэл хийх ба дэд нэгж талбарын талбайн хэмжээнээс хамааруулан мониторинг, бичиглэл, дээж авах цэгийн тоог тогтооно.

Энэ норматив баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт, арга зүйн дагуу нэгж талбар бүрийн төлөв байдал, чанарыг тодорхойлно.

### Нэгж талбарын дугаарыг мэдээллийн сан болон хүснэгтэд тэмдэглэх

Мэдээллийн санд нэгж талбарыг дугаарлахдаа аймаг, сумын кодыг ашиглана.

Нэгж талбарын дугаарын эхэнд бэлчээрийг В үсгээр, тариаланг Т үсгээр, хот сууринг С үсгээр, латинаар бичнэ.

Аймаг, сумын кодыг Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код, MNS5641-0-2006 2х, MNS5641-1-2006 6х, MNS5641-2-2006 34х, MNS5641-3-2006 47х стандартад заасны дагуу тэмдэглэнэ.

Үндсэн нэгж талбарын дугаар: С650101

Дэд нэгж талбарын дугаар: С650101-00001

Тайлбар: С-хот суурин газрын хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 01- үндсэн нэгж талбар, 00001-дэд нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

Нэгж талбар шинээр үүссэн бол өмнөх улсын хянан баталгааны дугаарыг үргэлжлүүлэн дугаарлана. Нэгж талбар хуваагдсан тохиолдолд С220100001а, С220100001б гэж дугаарлана.

Хэрэв өмнөх хянан баталгааны нэгж талбарын дугаар өөр өгөгдсөн бол түүнийг хайж олох хүснэгтийг тайланд хавсралтаар оруулна. Жишээ нь:

№	Газрын нэр	Өмнөх нэгж талбарын дугаар	Одоо өгч байгаа нэгж талбарын дугаар

**Мониторингийн цэг тэмдэглэх: M1 C650101-00001**

Тайлбар: Нэгж талбарын дугаарын өмнө үсэг, тоогоор тэмдэглэнэ. M1- мониторингийн цэгийн дугаар, С-хот суурин газрын хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 01-үндсэн нэгж талбар, 00001-дэд нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

**Ургамлын бичиглэлийн цэг тэмдэглэх: B1 C650101-00001**

Тайлбар: Нэгж талбарын дугаарын өмнө үсэг, тоогоор тэмдэглэнэ. B1- бичиглэлийн цэгийн дугаар, С-хот суурин газрын хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 01-үндсэн нэгж талбар, 00001-дэд нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

**Хөрсний дээж авсан цэг тэмдэглэх: D1 C650101-00001**

Тайлбар: Нэгж талбарын дугаарын өмнө үсэг, тоогоор тэмдэглэнэ. D1- хөрсний дээж авсан цэгийн дугаар, С-хот суурин газрын хянан баталгаа, 65-аймгийн код, 01-сумын код, 01-үндсэн нэгж талбар, 00001-дэд нэгж талбарын дугаарыг илэрхийлнэ.

**Нэгж талбарын хил зааг, дугаарыг зурагт тэмдэглэх**

Үндсэн нэгж талбарын дугаар, хилийг улаан өнгөөр, дэд нэгж талбарын дугаарыг хар өнгөөр, хилийг хар тасархай зураасаар тэмдэглэнэ.

**1.3. Агаар, сансрын болон дроноор авсан зураг ашиглах**

Хянан баталгаа хийхийн өмнөх 4-5 жилийн (жил бүрийн 7-8 сард авсан, үүлгүй, 5 м-ийн нарийвчлалтай) агаар, сансрын зургийг боловсруулж, жил бүрийн ургамлын нормчилсон индекс (NDVI)-ийн зураглал хийнэ. Агаарын зураг, дрон (нисгэгчгүй нисэх төхөөрөмж)-оор авсан зураг ашигласан бол боловсруулалтыг зааврын дагуу хийсэн байна.

Жил бүрийн зургийг харьцуулан, дүгнэж, тайланд дэлгэрэнгүй тайлбарлаж оруулна.

Дээрх боловсруулалт хийсэн зургаас хөрсний элэгдэл, эвдрэл, үер усны нөлөө, элсний нүүлт зэрэг нөлөөлөлд өртсөн газрын мэдээллийг тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэж, хээрийн судалгаагаар тодруулалт хийнэ.

Агаар, сансрын зураг авсан эх сурвалж, хэрэв боловсруулалт хийсэн бол ашигласан програм, зураг боловсруулалтын арга зүйн талаар бэлтгэл, эцсийн тайланд тодорхой, дэлгэрэнгүй тусгасан байна.

**1.4. Ажлын зураг**

Ажлын зураг нь хянан баталгааны ажлын зураг болох төдийгүй тухайн ажил хийгдэж дуустал эх материал болж ашиглагдана.

Урьд өмнө хийгдсэн судалгааны материал, баримт бичиг, статистикийн тоо баримт, газрын нэгдмэл сангийн тооллого, газрын улсын бүртгэлийн мэдээлэл, өмнө хийгдсэн хянан баталгааны материал, хөрс, ургамлын зураг, хянан баталгаа хийхээс өмнөх 4-5 жилийн агаар, сансрын зураг, 1:1000 масштабтай байр зүйн зураг, газрын кадастрын зураг ашиглан ажлын зураг бэлтгэнэ. Ажлын зурагт дараах тоон мэдээлэл суурь байдлаар ашиглагдах бол зарим мэдээллийг шинээр оруулна. Жишээ нь:

1. Хянан баталгаа хийгдэж байгаа аймаг, сумдын 0 гортиг, өмнө хийгдсэн хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийг тоон хэлбэрээр,
2. 1:100000 масштабын хөрс, ургамал, газрын нэгдмэл сангийн зургийг тоон хэлбэрээр,
3. Газрын кадастрын мэдээллийн сангаас газрын кадастрын зургийг тоон хэлбэрээр,
4. 1:100000 масштабын байр зүйн тоон зургийг тоон хэлбэрээр газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас авч ашиглана.
5. Өмнөх хянан баталгааны ажлаар тогтоосон бичиглэл хийсэн, дээж авсан цэгийг ажлын зурагт тэмдэглэнэ.
6. Шинээр байгуулах мониторингийн, бичиглэлийн, дээж авах цэгийн байршлыг ажлын зурагт тэмдэглэнэ.
7. Хатуу хучилттай болон барилгажсан талбай, ногоон байгууламж, элс нүүсэн газар, шороон зам, гуу жалга, хог хаягдлын талбайг ажлын зурагт тэмдэглэнэ.
8. Кадастрын зурагт ороогүй газрыг хиймэл дагуулын болон дрон ашиглан зураглана.

### **1.5. Мониторингийн цэг**

Мониторингийн цэгийг газрын гадарга, хөрсний хэв шинж, газар ашиглалтын төрөл, нягтаршилд дүгнэлт хийж, бэлтгэл ажлын хүрээнд урьдчилан тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэсэн байна.

Хот суурин газрын хянан баталгаанд 2 төрлийн цэг тогтооно. Үүнд:

1. Суурьшлийн бүсийн захад
2. Суурьшлийн бүс дотор

Суурин газрын 0 гортиг багтаан дэд нэгж талбар бүрт суурьшлийн бүсээс 500-1000 м зайд мониторингийн цэгийг тогтоож, хөрсний дээж авах, ургамлын бичиглэл хийх ажилбарыг гүйцэтгэнэ. Харин суурьшлийн бүсэд хүнд металлын болон биологийн бохирдолын хөрсний дээж авах, ургамлын бичиглэл хийх ажилбарыг гүйцэтгэнэ.

Мониторингийн цэг нь дараах шаардлагыг хангасан газарт байрлана. Үүнд:

1. Газар зохион байгуулалтын болон хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд зам, барилга зэрэг бүтээн байгуулалтад өртөхөөргүй газарт сонгосон байх
2. Одоо байгаа барилга байгууламж, хатуу хучилттай талбай болон эдгээр газраас 10-20 м зайд байрласан байх

### 3. Үер ус, хад чулуу зэрэг байгалийн хүчин зүйлийн нөлөөлөлд орохооргүй байх

Фото зураг авахдаа ойр орших уул болон онцлох тэмдэг бүхий газрыг фон болгох /эсвэл цагаан самбар ашиглаж болох/ бөгөөд үүнийг хөрсний бичиглэлийн маягт, мониторингийн хувийн хэрэгт ашиглана. Мөн эцсийн тайланг бичихдээ СД-д тоон хэлбэрээр хуулбарлаж ирүүлнэ.

- Аймгийн нэр
- Сумын нэр
- Цэгийн төрөл /бичиглэлийн, мониторингийн, дээж авсан/
- Цэгийн дугаар
- Солбицол
- Он сар өдөр

Мониторингийн цэгийн дугаарыг энэ аргачилсан зааврын 1.2-т заасны дагуу дугаарлаж, цэг бүрт хувийн хэргийг бүрдүүлнэ. Үүнд:

1. Хувийн хэргийн нүүр хуудсанд "... аймгийн .... сумын бэлчээрийн газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны мониторингийн сүлжээний .... дугаартай цэгийн хувийн хэрэг, ... он" гэсэн загвартай байна.
2. Мониторингийн цэгийн газрын гадаргын болон байршлын ерөнхий мэдээлэл
3. Мониторингийн цэгийн хөрсний бичиглэл
4. Мониторингийн цэгийн геоботаникийн бичиглэл
5. Мониторингийн цэгийн хянан баталгааны дүгнэлт буюу паспорт
6. Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулсан дүн шинжилгээ, дүгнэлт

#### 1.6.Бичиглэлийн цэг

Бичиглэлийг дараах 2 тохиолдолд хийх бөгөөд энэ аргачилсан зааврын 1.2-т заасны дагуу дугаарлана.

1. Мониторингийн цэгийн хөрс, ургамалжлын мэдээллийг баталгаажуулах зорилгоор хийнэ.
2. Маршрут судалгааны явцад нэмэлт хэмжилт хийх шаардлагатай бол хийнэ.

#### 1.7. Хөрсний судалгаа

Хөрсний судалгаанд дараах ажилбарууд орно. Үүнд:

- Хөрсний зүсэлт, малталт хийх
- Хөрсний дээж авах
- Хөрсний бичиглэл хийх
- Фото зураг авах
- Газрын гадаргын төрх байдлыг тодорхойлох (газар ашиглалтын байдал, хог ургамлын тархалт, хөрсний элэгдэл эвдрэл г.м)

### **1.7.1.Хөрсний зүсэлт, малталт хийх**

Хөрсний хэв шинжээр бүтэн зүсэлт хийх ба хөрсний үе давхрагаас хамаарч малталт хийж болно.

Зүсэлт болон малталтын тэгш хана нь нарны эсрэг байх ба хөрсний өнгөн үеэс 0 см эхлэхээр тохируулж 5 см-ийн алсгалттай өнгийн метр тавьж, хөрсний бичиглэл хийж, фото зургийг авна.

Нурсан эрэг буюу байгалийн нөхцлөөрөө байгаа хөрсийг ашиглан бичиглэл хийхгүй, хөрсний дээж авахгүй.

Ойр орших уул болон онцлох тэмдэг бүхий газрыг фон болгон /эсвэл цагаан самбар ашиглах/ дээж авсан цэгийн фото зургийг авч, солбицолыг тодорхойлж, зүсэлтийг 3-1, малталтыг М-1 гэж дугаарлаж, цэгийн байршлыг ажлын зурагт тэмдэглэнэ.

### **1.7.2.Хөрсний дээж авах**

Хот суурин газрын хянан баталгаанд зөвхөн хөрсний энгийн дээж авах бөгөөд холимог дээж авахгүй.

Хөрсний дээжийг авахдаа Байгаль хамгаалал. Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд MNS3298-90 стандартыг мөрдөнө.

Хөрсний дээжинд ямар шинжилгээ хийхээс хамаарч, давталт, жингийн хэмжээг тодорхойлно.

Хөрсний дээжийг мониторингийн цэгээс болон бохирдолтой газраас заавал авна. Тухайлбал:

- Газар ашиглалтын улмаас хөрс, ус, агаарт химийн хорт бодис хуримтлагдах, улмаар нэгээс нөгөөд дамжих нөхцөлтэй бол химийн бохирдолт гэж үзэж хөрсний дээж авна.
- Хүнсний ногооны хүлэмж, талбайд химийн бордоо ба гербицид, инсекцид хэрэглэсэн, түүнчлэн химийн янз бүрийн бодистой харьцдаг үйлдвэр аж ахуйн газар, агуулахын орчимд хөрсний бохирдолт байж болзошгүй учир хөрсний дээж авна.
- Хөрсний эрүүл ахуйн байдал доройтсон, өвчин үүсгэгч бичил биет, вирус байх магадлалтай газруудыг биологийн бохирдолд хамааруулан үнэлэхдээ хөрснөөс дээж авч, гэдэсний савханцрын, перфрингенсийн таньцыг илрүүлэх задлан шинжилгээг хийлгэнэ. Гэр хороолол, хүнсний үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг газрууд, нийтийн хоол, худалдаа үйлчилгээний төв, хүнсний захууд, иргэн, аж ахуйн нэгж, албан байгууллагын хашаа буюу харъяалалтай газрын дотор ба гадны орчинд биологийн бохирдлын тархалт, зэрэглэлийг тогтооно.

### **1.7.3. Усны дээж авах**

Усны дээжийг тухайн хот суурин газрын 0 гортигт ашиглаж байгаа худаг уст цэг, урсгал уснаас усны дээж авч холбогдох шинжилгээг хийнэ.

### **1.7.4. Газрын гадаргын төрх байдлыг тодорхойлох**

Газрын гадаргын төлөв байдалд үнэлэлт, дүгнэлт өгөхдөө газрын гадаргыг өөрчилснөөс буюу гадаргын ерөнхий тогтоцоос шалтгаалж, гэнэтийн аюулд өртөх, техникийн аюулгүй байдал, хөдөлгөөнд саад тотгор учруулах, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэх бодит нөхцөл байгаа эсэхийг тодруулна.

Ухсан нүх, овоолго, тогтсон шалбааг, нурсан барилга, барилгын хаягдсан ором, уурын зуухын үнс, нүүрсний хог, ахуйн хаягдал болон хөрсний зулгаралт, ургамлын талхлагдал гэх мэт өөрчлөлтийг физик бохирдолд хамруулж, талбайн хэмжээг тодорхойлно.

Аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрийн газар, иргэдийн ашиглаж, эзэмшиж байгаа газрын гадаргын төлөв байдал, гадаргын бохирдолт, гадны хүчин зүйлийн үйлчлэлээр бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын тусгаг бүрхэвч зэргийн судална. Хэрэв үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг бол үйл ажиллагааны технологийн онцлогтой газар дээр нь танилцсан байна.

Ялангуяа түүхий эд боловсруулалт, дагавар болон үндсэн бүтээгдэхүүн, түүнчлэн дамжлага бүрт ялгарч гарах хаягдал, бохир, тэдгээрийн дамжуулалт хадгалалт, цэвэршүүлэлт зэргийг онцгойлон судлана. Мөн бохирдол, өөрчлөлттэй холбоотой объектуудын фото зургийг авч тайланд тайлбарлан оруулна.

Дэд нэгж талбар бүрээр дараах асуудлуудыг тодруулж, ажлын зурагт тэмдэглэнэ. Үүнд:

- газрын гадаргын бохирдол, хөрсний зулгаралт, гуу жалга зэрэг өөрчлөлтийг агаар, сансрын зургаас тодруулж, талбайн хэмжээг тодорхойлж, шалтгааныг тодруулж, ажлын зурагт тэмдэглэж, хянан баталгааны дүгнэлт болон актад заавал тусгана.
- газар ашиглалтын эмх цэгц, автозамын хөдөлгөөний тэмдэгжүүлэлт ялангуяа орчны тохижилтыг хөрсний элэгдэл эвдрэл, бохирдолттой холбон үзэж дэд нэгж талбар бүрээр тэмдэглэл хийнэ.
- Хашаа хорооны хогийн ба ялгадасны цэг, муу усны цооног, мөн хашааны доторхи болон гудамж талбайн зүлэгжүүлэлт, явган хүний зам талбайн хүрэлцээ, төлөв байдал ямар байгаад үнэлэлт өгнө.
- Аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрийн газар, айл өрх, иргэдийн эзэмшил газрын эргэн тойрны ургамлан бүрхэвчийн талаар судалж, ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тусгаг бүрхэцийг тодорхойлж, дэлгэрэнгүй бичиглэл хийнэ.
- Газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам ба автомашины замыг цэгцлэх, хөрс, ургамлан бүрхэвч талхлагдахаас сэргийлэх талаар дүгнэлт хийхэд анхаарна.

- Газар ашиглалтын аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, өндөр хүчдэлийн шугам, галын аюул гэх мэт нийгэм-эдийн засаг, байгаль орчинд сөрөг нөлөөлөх үзүүлэлтүүдийг судлан тогтоож дүгнэлтийг гаргах ба хэрэгжүүлэх арга хэмжээг дэлгэрэнгүй тусгана.

### 1.Суурин газарт физик бохирдол буюу өөрчлөлт хамгийн их тархалттай байдаг.

Физик өөрчлөлтийг зориулалтын ба зориулалтын бус, энэ өөрчлөлт хүрээлэн буй орчинд хэрхэн нөлөөлж байгааг бодитой тодорхойлоход хянан баталгааны ажлын зорилго юм.

Физик өөрчлөлтийн хамгийн энгийн жишээ бол газрын гадарга, хөрсний зулгаралт, ургамлын талхлагдал юм. Барилга байгууламжийн талбай хөрсгүй, ургамалгүй байх нь мэдээж, харин түүний орчимд хүний ба техникийн хөдөлгөөнийг эмхэлж, цэгцэлсэн, бусад талбайг хөрсжүүлж, ургамалжуулсан байх шаардлагатай. Гэтэл ихэнх байгууллага, иргэний хашаатай газар нь улаан халцгай, хөдөлгөөнийг цэгцэлж журамлаагүй байдаг. Эндээс хотын дотор шороо шуурч агаар, ус, бүгд бохирдож байдаг тул хөрс, ус, агаарын бохирдолын асуудлыг хамтад нь судлах шаардлагатай.

Физик бохирдолд ухсан нүх, овоолсон хог, тогтсон шалбааг, нурсан барилга, барилгын хаягдсан ором, уурын зуухны үнс, нүүрсний хог, өмөрсөн цардмал зам, талхлагдаж шарлаж ургасан зүлэг, өмхөрсөн мод, ургамал зэрэг зүйлс орно.

Өөрөөр хэлбэл барилга байгууламжийн суурь дэвсгэр ба авто зам, зогсоолоос бусад бүхий л талбай, ургамлан нөмрөггүй өөрийн биологийн буюу ногоон ургамал фотосинтезийн процесс явуулах боломжгүй газарт физикийн доройтол болно. Физикийн бохирдол, доройтол ихэвчлэн гадаад хэлбэр талаасаа илэрнэ. Харин нэгэнт физикийн бохирдол доройтолд орсон газар цаашид химийн ба биологийн бохирдолд өртөхдөө хялбар болно.

### 2.Газар ба түүний бүрэлдэхүүн хөрс, ус, агаарт газар ашиглалтын улмаас химийн хорт бодис хуримтлагдах, улмаар нэгээс нөгөөд дамжих процессыг газрын химийн бохирдолт гэж үзнэ.

Химийн хорт бодисын үүсэл ба хуримтлалын процесс тийм ч өргөн биш боловч хор хөнөөл, үр дагавар нь хурц илэрдэг онцлогтой.

Химийн хорт бодис үүсэх, хуримтлагдах явдал 1-т үйлдвэрлэл үйчилгээний технологийн онцлогтой, химийн бодистой харьцдаг газарт, тэдгээрийн хадгалалт хэрэглээг сайтар судалж үзэх шаардлагатай.

Ялангуяа хүнд ба хөнгөн үйлдвэр, нефтийн бүтээгдэхүүний хадгалалт, хэрэглээнд хяналт тавих, эдгээр үйлдвэрийн бохирын систем, түүний дамжуулалт, цэвэрлэгээ дахин хуваарилалтыг байгаль орчны ба эрүүл ахуйн талаас үзэж, үнэлэлт дүгнэлт өгөх, химийн бодисын үйлчилгээг хүлцэх чадвар ба хөрс, усны нөөцтэй холбож үзэх, химийн бодисын хэрэглээний талаар хүмүүсийн дунд санал асуулга явуулах, хүнд үйлдвэрийн орчмын газарт химийн хүнд элемент, цацраг идэвхт бодисыг тодорхойлох шаардлагатай.

Хүлэмжийн аж ахуйн хөрсөнд химийн бордоо, гербицид, инсекцидийн үлдэгдэлд анхаарах, хөрсөөр дамжин газрын гадарга, гүний ус, агаарт химийн бодис хуримтлагдаж орчныг бохирдуулж байгаа эсэхийг хянах шаардлагатай.

Химийн бохирдол ихэвчлэн толбо хэлбэрээр үүсдэг болохыг сайтар анхаарч дээж авах ба ажиглалт хийх цэгийг зөв сонгох хэрэгтэй.

3.Биологийн бохирдол гэр хороолол, хүнсний үйлдвэр, нийтийн худалдаа үйлчилгээний болон хүнсний захын орчимд их байдаг.

Энэ нь хүнсний бүтээгдэхүүний ил задгай талбайд үйлдвэрлэл үйлчилгээ их байгаа, бохирын системийн ажиллагаа муутай холбоотой. Ялангуяа дулааны улиралд газар, хөрс, ус, агаар биологийн гаралтай бохирдол их байна.

Биологийн бохирдол юуны өмнө үнэрээр илэрнэ. Гэхдээ ихэнх тохиолдолд хөрс, уснаас тусгай стандартын дагуу дээж авч, мэргэжлийн итгэмжлэгдсэн лабораторит шинжилгээ хийлгэнэ.

Хээрийн ажлын үе шатанд газрын бохирдол, өөрчлөлттэй холбоотой обектуудын фото зургийг авна. Биологийн бохирдол тархалт, зэрэглэлийг тогтоохдоо тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хашаа буюу харъяалалтай газрын дотор ба түүний гадна орчныг сайтар анхаарна. Өөрөөр хэлбэл өөрийн хашааны гадна ялгадас, хогоо овоолж бохирдуулдаг тохиолдол их байна.

### 1.8.Бэлтгэл ажлын тайлангийн агуулга

- **Нүүр хуудас** хүрээтэй байх ба дотор нүүр хуудсанд захирал болон ажилтнууд гарын үсэг зурж, тамга дарсан байна. (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /12, томоор/)
- Гарчиг (хуудасны дугаартай байх)
- **Ерөнхий мэдээлэл** (ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, хугацаа, гүйцэтгэгчийн нэр, тусгай зөвшөөрлийн талаарх товч мэдээлэл, баримталсан эрх зүйн баримт бичгийн нэр /жагсаалт, баталсан эрх бүхий этгээдийн нэр/ /хуулийн заалтуудыг нэг бүрчлэн бичихгүй/, урьд нь тухайн хянан баталгааг гүйцэтгэсэн талаарх мэдээлэл, гүйцэтгэх ажлын хүрээнд хийхээр төлөвлөсөн ажлын жагсаалт, хугацаа, биелэлт, цуглуулсан материалын жагсаалт, дүн шинжилгээ хийсэн арга г.м)
- **Ажлын зураг боловсруулалтын тухай** (агаар, сансрын зураг боловсруулалтын тухай буюу хиймэл дагуулын нэр, танилцуулга, авсан эх сурвалж, дугаар, нийт сценений /цуваа/ тоо, нарийвчлал, файлын хэмжээ, зураг ашиглан тодруулалт хийсэн болон NDVI зураглал хийсэн арга зүй, ажлын зураг боловсруулахад хэрэглэсэн зураг мэдээллийн жагсаалт, эх сурвалж, он, зөрүүтэй байдлыг зассан тухай тайлбар, үндэслэл, өмнөх хянан баталгааны зургийн тусгагт шилжүүлсэн эсэх, ажлын зургийн үндсэн тусгаг, боловсруулалт хийсэн програм, ажлын зурагт тэмдэглэсэн цэгийн төрөл, солбицолын жагсаалт, үндэслэл, эх сурвалж, он, хээрийн судалгааны маршрут, дроноор авсан зураг



ашигласан бол зургийн талаарх мэдээлэлийг энэ бүлэгт бичнэ. Ажлын зурагт уур амьсгалын болон хянан баталгааны нэгж талбарын зураг, мониторинг, дээж авах, бичиглэл хийх цэгийн байршил, хөрсний зураг, зүсэлт хийх цэг, шинээр атар хагалсан газрууд зэргийг харуулсан байна)

- **Байгаль, нутаг дэвсгэрийн ерөнхий нөхцлийн мэдээлэл** (хянан баталгаа хийгдэж байгаа газрын газар зүйн байршил, газрын гадарга, цаг уур, хөрсөн бүрхэвч, ургамалжилтын мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж, тайлбарлан бичнэ. Мөн холбогдох зурган мэдээллийг /газрын гадаргын өндөржилтийн зураг, цаг уурын зураг, хөрс, ургамлын зураг/ оруулна. Сансрын зураг, газар ашиглалт, хөрс, ургамлын зураглал, кадастрын зураг, байр зүйн зураг, газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл, газар ашиглалтын статистик мэдээлэл, газрын нэгдмэл сангийн тайлан, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, тайлбарыг оруулна. Энэ бүлгийг эцсийн тайланд ашиглах тул сайтар бичихээс гадна эх сурвалж, оныг заавал өгүүлбэр бүрийн ард хаалтанд оруулах, ашигласан материалын жагсаалтад цагаан толгойн дарааллаар оруулсан байна.)
- **Хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө** /хээрийн судалгаа хийх ажлын төлөвлөгөө, оролцох хүмүүсийн нэр, гүйцэтгэх үүрэг, хугацаа зэргийг хүснэгтээр харуулна. Хээрийн судалгааны маршрут, км, урьдчилан тогтоосон дээж авах, бичиглэл, мониторингийн цэгийн тоо, байршил зэргийг зургаар харуулж, дэлгэрэнгүй тайлбарласан байна. Хээрийн судалгаанд ашиглах техник, багаж хэрэгслийн жагсаалт, лабораторын болон бусад чиглэлээр хамтран ажиллах гэрээний хуулбар, хамтрагч байгууллагын хийх ажлын жагсаалт, шинжилгээний арга, хугацаа, үнэ өртөг, магадлан итгэмжлэгдсэн эсэх, лабораторийн товч түүх г.м/
- **Ашигласан материалын жагсаалт:** Хууль, журам, зааврыг хамгийн эхэнд оруулах ба зохиогчийн болон байгууллагын бүтээлийг тус тусад нь цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаана. Жагсаахдаа зохиогчийн нэр, овгийн үсэг, зохиолын нэр, хэвлэсэн он, хэвлэсэн газар/баталсан байгууллагын нэр зэрэг дарааллаар бичнэ.
- **Хавсралт:** (орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн албан бичиг, хамтран ажиллах гэрээний хуулбар г.м)
- **Баталгааны хуудас**  
(Архивын шаардлага: Тайлан засваргүй гэж үзсэн бол нүүрэн талд 2 хуудас хүснэгт оруулж, тайлангийн хуудас бүрийг дугаарлаж, архивын (бор) хавтсаар хавтаслаж, үдсэн (цагаан утас) байна)

### 1.9.Бэлтгэл ажлын захиалагчийн хяналт

Бэлтгэл ажлын тайланг 2 хувь хэвлэж, захиалагчид албан бичгийн хамт ирүүлэх бөгөөд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хариуцсан нэгжийн хот тосгон, бусад суурин газрын

төлөв байдал, чанарын хянан баталгаа хариуцсан мэргэжилтэн тайланг дараах дарааллын дагуу шалгана. Үүнд:

1. Тайланг аргачилсан зааварт заасан агуулгаар бичигдсэн эсэх (дэд гарчиг бүрт заасан санааг оруулсан байдал)
2. Найруулгын болон үсгийн алдаа байгаа эсэх
3. Эх сурвалжийг дурьдсан эсэх (Эх сурвалж /ном, сэтгүүл, иш татсан материал/ ашигласан тохиолдолд нэр, хуудасны дугаар бичсэн байна.)
4. Зураг, хүснэгтийн нэр, масштаб, таних тэмдэг ашиглалт
5. Байгаль нутаг дэвсгэрийн ерөнхий мэдээлэл ойлгомжтой бичигдсэн байдал

Хэрэв тайлан шаардлагыг хангаагүй, бэлтгэл үе шатант хийх ажил хангалтгүй бол ажил шалгасан акт гарахгүй байх, хээрийн судалгаанд гаргахгүй байх үндэслэл болно.

## **ХОЁР.ХЭЭРИЙН СУДАЛГАА**

Хээрийн судалгаа нь хянан баталгааны ажлын гол хэсэг бөгөөд үүнээс ажлын гол үр дүн хамаарна.

Хээрийн судалгаа нь ярилцлагын судалгаа, ургамлын судалгаа, хөрсний судалгаа, усны дээж авах, тэдгээрийн цэгийг тогтоох, захиалагчийн хяналт гэсэн хэсгээс бүрдэнэ.

Энэ ажилд орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн, сумын газрын даамал заавал оролцоно. Энэ нь хээрийн судалгаанд орон нутгийн төлөөллийг оролцуулах, хээрийн судалгааг газар дээр нь хэрхэн хийж байгаатай танилцах, суралцах, захиалагчийн хяналтын үүргийг давхар гүйцэтгэх боломж бүрдэнэ.

Хээрийн судалгааны ажлын хүрээнд аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрийн газар, иргэдийн ашиглаж, эзэмшиж байгаа газрын гадаргын төлөв байдал, гадаргын бохирдолт, гадны хүчин зүйлийн үйлчлэлээр бий болсон хөрсний элэгдэл, эвдрэл, хог ургамлын тархалт, усны эвдрэлээр үүссэн гуу жалга, элсний нүүлт, гадаргын чулуужилт, хог хаягдлын цэгүүд, түүний орчны бохирдлыг тогтоох ажил хийгдэнэ.

Кадастрын зургийг сансрын зурагтай давхцуулсан ажлын зургийг тодруулах зорилгоор шинээр барьж байгуулсан объект, гарсан өөрчлөлтийг тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэнэ.

### **2.1.Ярилцлагын судалгаа**

Ярилцлагын судалгааг дараах байдлаар явуулна.

1. Хээрийн судалгаа хийхийн өмнө орон нутгийн хүмүүс, удирдлага, газрын даамал, аймгийн ГХБХБГ-ын мэргэжилтэнтэй уулзаж, суурин газрын бохирдол, эвдрэл, үер усны нөхцөл байдал, хөрсний эрүүл ахуй, хүн амын дундах өвчлөл, агаар, усны бохирдлын талаар мэдээлэл солилцоно.

2. Орон нутгийн удирдлага, Байгаль орчны газар, Мэргэжлийн хяналтын газар болон газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдлага, мэргэжилтэн, газрын даамалд хянан баталгааны ажлын зорилго, чиглэл, ач холбогдол, хээрийн судалгаа хийх газрууд болон хийгдэх ажлыг танилцуулж, суурин газрын орчны бохирдол, хөрс, ургамлын өөрчлөлт, элэгдэж эвдэрсэн болон хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авсан газруудыг тодорхойлж, ажлын зурагт тодотгол хийнэ. Мөн хүнд металлын бохирдолтой газрууд, химийн болон биологийн бохирдол ихтэй газруудын байршлыг тодорхойлно.
3. Хээрийн судалгааны бэлтгэсэн маршрутыг хэлэлцэн, орон нутгийн санал, дүгнэлтийг нэмж тусган хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулна.
4. Бэлтгэл үе шатанд тогтоосон хээрийн судалгааны маршрутыг хэлэлцэж, орон нутгийнханы саналыг харгалзан судалгаа хийх нэмэлт газруудыг тодорхойлж, ажлын зурагт тэмдэглэж, судалгааны маршрутыг тодотгоно.
5. Орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивт болон сумын газрын даамалд байгаа хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын болон захиалгат хянан баталгаатай холбоотой акт, баримт бичгийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалт, ашиглалтын талаар дүгнэлт хийж, хээрийн ажлын тайланд тусгасан байна.

Ярилцлагын арга нь сумын удирдлага, малчдын оролцоог хангах, хээрийн судалгааны маршрутыг тодотгох, шаардлагатай газруудын мэдээлийг нарийвчлах, хээрийн ажлын маршрут, хугацааг хэмнэх зэрэг олон давуу талтай тул зайлшгүй хийх шаардлагатай.

## 2.2.Хянан баталгааны үзүүлэлтийг тодорхойлох

### Хянан баталгааны үзүүлэлт

хүснэгт 3

№	Үзүүлэлт	Тодорхойлох арга
1	Газрын гадаргын төрх байдал (хөрсний зулгаралт, элэгдэл, эвдрэл)	Агаар сансрын зургаас дараах эвдрэлийг тодорхойлж, зураглаж, талбайн хэмжээг тогтооно. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Хатуу хучилттай талбай</li> <li>• Авто зам</li> <li>• Гуу жалга</li> <li>• Элсний нүүлт</li> <li>• Хурсан элсний зузаан</li> <li>• Техникийн нөлөөгөөр зулгарах</li> <li>• Халцгай буюу ургамлан нөмрөггүй газар г.м</li> </ul>
2	Ногоон байгууламж ба хог ургамлын тархалт	Ургамлын бичиглэл хийх аргаар тодорхойлж, хог ургамлын тархалт, байршлыг зурагт тэмдэглэнэ.
3	Хөрсний механик бүрэлдэхүүн	Хөрсний 0-10 см болон 10-20 см гүнээс авсан дээжинд лабораторын аргаар тодорхойлно.
4	Хөрсний PH	Хээрийн нөхцөлд болон лабораторын аргаар тодорхойлно.
5	Хөрсний ялзмагт үеийн зузаан	Хөрсний зүсэлт, малталт хийсэн газарт см-ийн хуваарьтай шугамаар хэмжиж, хөрсний бичиглэлийн маягтад тэмдэглэнэ.

6	Хөрсний ялзмагийн агууламж	Хөрсний 0-10 см болон 10-20 см гүнээс авсан дээжинд лабораторын аргаар тодорхойлно.
7	Хөрсний бохирдол (нянгийн тоо, Колититр, перфингенсийн титр)	Хөрсний 0-10 см болон 10-20 см гүнээс авсан дээжинд лабораторын аргаар тодорхойлно.
8	Хөрсний хүнд металлын бохирдол	Хөрсний 0-10 см болон 10-20 см гүнээс авсан дээжинд лабораторын аргаар тодорхойлно. Тухайн ямар элементээр бохирдох магадлалтайг тодорхойлж, лабораторит ямар элементийг тодорхойлохыг шинжээч тогтооно.
9	Усны шинжилгээ	Ахуйн ундны зориулалтаар ашиглаж байгаа гүний болон гадаргын уснаас авсан дээжинд лабораторын аргаар тодорхойлно.

### **2.3.Газрын гадаргын төрх байдал (хөрсний зулгаралт, элэгдэл, эвдрэл)**

Газар ашиглалтын эмх цэгц ялангуяа орчны тохижилтыг хөрсний элэгдэл эвдрэл, бохирдолттой холбон үзэж, дэд талбар бүрээр нь бичиглэл хийж тэмдэглэнэ.

Тухайлбал, автозамын хөдөлгөөний тэмдэгжүүлэлт, хашаа хороонд хогийн ба ялгадасны цэг, муу усны цооног мөн түүнчлэн хашааны доторхи болон гудамж талбай зүлэгжилт, явган хүний зам орчим г.м.

Хот суурин газрын гадаргын төрх байдлыг дараах байдлаар ангилан тодорхойлж болох ба орон нутгийн онцлогоос хамааруулан нэмэлт ангилалаар ангилж болно. Үүнд:

1. Автозам үүссэн талбай
2. Үер, усны эвдрэлд орсон талбай
3. Барилга, дэд бүтэц, автозамын бүтээн байгуулалтын улмаас үүссэн элэгдэл эвдрэлд орсон талбай
4. Цэргийн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон талбай
5. Халцгай буюу ургамлан нөмрөггүй талбай г.м

Эдгээр талбайг агаар, сансрын зургаас тодорхойлж, хээрийн судалгаагаар шалгаж тодруулна.

### **2.4. Ногоон байгууламж ба хог ургамлын тархалт**

Хот суурин газрын ногоон байгууламж, ургамалжилыг дараах 3 бүлэгт хувааж үзнэ. Үүнд:

1. Бэлчээр бүхий хог ургамалд өртөөгүй газар
2. Хог ургамалтай талбай
3. Ногоон байгууламж

Эдгээрийг агаар, сансрын зураг дээр урьдчилан тодорхойлж, газар дээр нь тодруулж, талбайн хэмжээг гаргах бөгөөд хээрийн судалгаагаар тодруулахдаа ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, тусгаг бүрхэцийг 3 давталттай тодорхойлно.

Ногоон байгууламжид ургасан модны нэрийг бичиглэлд бичсэн байна.

## **2.5.Хөрсний механик бүрэлдэхүүн**

Хөрсний механик бүрэлдэхүүнийг лабораторын нөхцөлд тодорхойлно.

## **2.6.Хөрсний PH**

Хээрийн болон лабораторын нөхцөлд тодорхойлно.

## **2.7.Хөрсний ялзмагт үеийн зузаан**

Хээрийн нөхцөлд хөрсний зүсэлт, малталт хийж тодорхойлно.

## **2.8.Хөрсний ялзмагийн агууламж**

Хөрсний ялзмагийн агууламжийг лабораторын нөхцөлд тодорхойлно.

## **2.9.Хөрсний бохирдол**

Хөрс бохирдсон, өвчин үүсгэгч бичил биет, вирус байх магадлалтай газруудыг биологийн бохирдолд хамааруулан үнэлэхдээ хөрснөөс дээж авч, лабораторын нөхцөлд тодорхойлно. (ахуйн зориулалтай үйлдвэр, үйлчилгээ, хүнсний зах, сургууль, цэцэрлэг, гэр хороолол г.м хүн ам олноор суурьшсан төвлөрсөн усан хангамжинд холбогдоогүй газар)

Нянгийн бохирдлыг Хөрсний чанар. Хөрсөнд эрүүл зүйн нян судлалын шинжилгээ хийх арга (MNS 6341:2012) стандартаар тогтооно.

Хот, суурин, пионерийн зуслан, рашаан сувилал, амралт, сургууль, хүүхдийн байгуулага бүс газар, усан хангамжийн эх булаг, үйлдвэрийн ариун цэврийн хамгаалалтын бүс, зам тээвэр, хөдөө аж ахуй, ойн эдлэн газар, худалдаа, үйлчилгээний байгууллагын газрын хөрсний ариун цэврийн үзүүлэлтүүдийн норм, хэмжээг Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ (MNS3297-1991) стандартын дагуу тогтооно.

Хөрсний бохирдлыг дараах үзүүлэлтээр тогтооно. Үүнд:

1. 1 гр хөрсөнд агуулагдах нянгийн тоо
2. Гэдэсний бүлгийн савханцарын таньц
3. Перфингесийн таньц

Хөрсний нянгийн бохирдлын зэрэг

Хүснэгт 4

Бохирдлын зэрэг	Нянгийн ерөнхий тоо	Гэдэсний савханцарын таньц	Перфингесийн таньц
-----------------	---------------------	----------------------------	--------------------

Цэвэр	100-1000	1.0>	0.1
Бохирдол багатай	1000-с их	0.1-0.01	0.1-0.01
Дунд зэргийн бохирдолтой		0.01-0.001	0.01-0.0001
Их бохирдолтой		0.0001<	0.0001<

Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дээжийг 0-5, 5-10 см-ээс авна. Дээжийг 6 цагийн дотор лабораторид хүргэх ёстой бөгөөд дээжийг +1-ээс -2 градуст барьж чадсан тохиолдолд хадгалах хугацааг 24 цаг хүртэл сунгах боломжтой.

Эрүүл ахуйн сорьц авах, түүнийг хадгалах, тээвэрлэх асуудал нилээд бэрхшээлтэйн зэрэгцээ дээж задлан шинжилгээний ажлыг нэн хязгаарлагдмал хүрээнд хийнэ.

Шинжилгээний дүнг стандарт хэмжээтэй харьцуулахаас гадна тухайн суурин орчмын эрүүл газрын (хөрсний хэв шинж болон газрын гадарга, дээж авсан гүн ижил байх) хөрсний шинжилгээний дүнтэй харьцуулж болно.

## 2.10. Хөрсний хүнд металлын бохирдол

Хот суурины газрын орчны бохирдолтод хатуу хог, бохир усны систем, ариутгалын систем, үйлдвэрлэлийн технологитой холбоотой асуудал хамаарна.

Үйлдвэр, уул уурхайн технологи, үйлдвэрлэлтэй холбоо бүхий хордолт байхыг үгүйсгэхгүй. Ялангуяа зарим хүнд металл цацраг идэвхт бодис зэрэг бохирдолт, хордолтын баттай мэдээлэлтэй байх эсвэл байж болох нөхцөл бүрдсэн үед лабораторын шинжилгээ хийлгэнэ.

Химийн янз бүрийн бодистой харьцдаг үйлдвэр аж ахуйн газар, агуулахын орчимд хөрс бохирдолт байж болзошгүй. Үйлдвэр уурхайн газарт технологийн сонголтоос хамаарч газар нутгийн ашиглалт, хамгаалалтад нилээдгүй өөрчлөлт гарч болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Хүнд металлаар бохирдсон газрыг дараах байдлаар бүлэглэж болно. Үүнд:

1. Уурын зуухны газрын орчмын бохирдол
2. Техникийн болон авто засварын газрын ойр орчмын бохирдол
3. ШТС-ын орчмын газрын бохирдол
4. Хогийн цэг, угаадас хаясан газрын бохирдол
5. Химийн бодис ашиглаж буй газрын бохирдол
6. Арьс ширний үйлдвэрийн газрын бохирдол
7. Хүнсний болон бүх төрлийн зах орчмын газрын бохирдол
8. Булаг, худаг уст цэгийн эрүүл ахуйн бүсийн орчны бохирдол
9. Авто замын дагуух газрын бохирдол

## 10. Цэвэрлэх байгууламжийн орчны газрын бохирдол

Хөрсний хүнд металлын бохирдол нь тухайн орчны газар ашиглалт, хэрэглэсэн химийн бодис, бохирдуулж байгаа эх үүсвэрээс хамаарах тул хээрийн судалгааны явцад тодорхойлох шаардлагатай хүнд металлыг зааж, лабораторын шинжилгээнд оруулна. Өөрөөр хэлбэр гэр хорооллын газарт автомашины утаа, нүүрсний утааны нөлөөгөөр хөрсний өнгөн гадарга хүнцэл буюу мешъяк, хар тугалга зэрэг элементээр бохирдох магадлалтай тул эдгээрийн шинжилгээг хийлгэнэ.

Хүнд металлын шинжилгээний дээж авах газруудыг ажлын зураг дээр урьдчилан тодорхойлсон байх бөгөөд хээрийн судалгаагаар дээж авах цэгийн солбицол, нэмэлт дээж авах асуудлыг нарийвчлан тогтооно.

Хөрсний хүнд металлын шинжилгээний дүнг стандарт хэмжээтэй харьцуулахаас гадна тухайн суурин орчмын эрүүл газрын (хөрсний хэв шинж болон газрын гадарга, дээж авсан гүн ижил байх) хөрсний шинжилгээний дүнтэй харьцуулж болно.

### 2.11. Усны шинжилгээний дээж авах

Нүдэн баримжааны ажиглалтын үед гадаргын болон ундны ус, үйлдвэрлэлийн болон ахуйн хаягдал тогтоол ус зэрэг нь ердийн биш, бохирдолтой /загас болон бусад усны организм, ургамал үхсэн, усны ёроолоос хий ялгарч байгаа, хэт булингар, ер бусын өнгө, үнэр, хөөс давхарга үүссэн г.м/ байвал усан орчны чанарын үзүүлэлтийг тодорхойлох зорилгоор усны дээж авна.

Сорьц авалт нь шинжилгээний нэг чухал хэсэг төдийгүй шинжилгээний дүнд зохих ёсоор нөлөөлдөг учир дээж материал сорьц авахдаа тухайн шинжлэх усыг бүрэн төлөөлж чадахуйц зөв авах хэрэгтэй. Сорьцыг буруу цэгээс авах, бохир саванд авах, орчны бичиглэл үйлдэхгүй байх, амархан хувирамтгай нэгдлүүдийг газар дээр нь тодорхойлоогүй зэрэг нь тухайн усны чанар, найрлага, бохирдлыг үнэлэхэд сөрөг нөлөө үзүүлнэ. Усны төрөл бүрийн эх булгаас сорьц авах арга нь харилцан адилгүй байдаг.

Сорьцонд хаяг бичихдээ аймаг, сум, баг, газрын нэр, голын нэр, байршил, цооногийн гүн, ундарга, сар өдөр, газар дээр нь тодорхойлсон физик үзүүлэлтүүд (өнгө, үнэр, амт, тунгалаг чанар, хийтэй эсэх)-ийг бичих ёстой.

Хээрийн судалгааны үед усны зарим шинжилгээг газар дээр нь хийнэ.

- Усны үнэр
- Усны амт
- Усны өнгө
- Булингаршил, тунгалагшил

#### Усны үнэр

Усны үнэр нь температур, ууссан хийнүүд болон органик ба эрдсийн бодисуудын найрлагаас хамаарна. Үнэрийг мэдэрхүйн эрхтэний тусламжтайгаар тодорхойлж, баллаар үнэлнэ. Үнэр нь байгалийн ба байгалийн бус гэж хуваагдана. Байгалийн гаралтай үнэрт усанд амьдрагч организмууд тэдгээрийн үхэж мөхөх, ургамлын ялзрал

зэргээс шалтгаална. Байгалийн бус гаралтай үнэр нь үйлдвэр ахуйн бохирдолтоос хамаардаг.

Цэвэр үнэргүй шилэн саванд ойролцоогоор эзэлхүүний 2/3 хүртэл ус хийж, шилэн болон үйсэн бөглөөгөөр бөглөж сэгсэрч бөглөөг авч үнэрийг тодорхойлно.

#### Үнэрийн ангилал

Хүснэгт 5

№	Үнэрийн шинж байдал	Ойролцоо үнэр
1	Тааламжтай	Цэцэгний, өргөст хэмхний
2	Намгийн	Лаг шавар
3	Ялзарсан	Бохир эхүүн
4	Модны	Модлог нойтон, үндэс, холтос
5	Газрын	Шинэхэн хагалсан газрын, шаврын
6	Хөгцөрсөн	Хөгцний
7	Загасны	Загас, загасны тос
8	Хүхэрт устөрөгчийн	Ялзарсан өндөгний
9	Ногооны	Өвс ногооны
10	Химийн	Химийн ямар нэг боловсруулалтаас үүссэн, тухайн элементийн, үйлдвэрийн бохир ус
11	Хлорын	Үлдэгдэл чөлөөт хлорын
12	Нүүрс төрөгчийн	Бензиний, нефть, шатах тослох материалын
13	Тодорхойгүй	Үнэртэж байгаа боловч төсөөлөх үнэргүй

#### Үнэрийг баллаар тодорхойлох

Хүснэгт 6

Балл	Үнэр	Үнэрийн шинж байдал
0	Ямар ч үнэргүй	Мэдэгдэхүйц үнэргүй
1	Маш сул	Хэрэглэгчдэд үл мэдэгдэх, ажиглагчдад мэдэгдэхүйц
2	Сул	Хэрэглэгчдэд үл мэдэгдэх ба хэлснээр мэдэж болох
3	Мэдэгдэхүйц	Илэрхий мэдэгдэхүйц, унданд хэрэглэж болохооргүй
4	Хурц	Эвгүй, шууд мэдэгдэхээр, унд ахуйд зохимжгүй
5	Маш хүчтэй	Ууж болохгүй, их хурц үнэртэй



Ундын ус ямарч үнэргүй байх ёстой бөгөөд үнэр нь стандартад зааснаар 2 баллаас хэтрэх ёсгүй.

**Усны амт:**

Усны амтыг давслаг, гашуун, исгэлэн, хүчиллэг гэж ангилж болно. Ил задгай усын амтыг тодорхойлохдоо буцалгаж хөргөөд, хлоржуулсан усыг 30 мин гоожуулсаны дараа тодорхойлно. 15 мл усыг балгаж залгилгүйгээр хэдэн секунд байлгаж баллаар үнэлнэ.

Амтыг баллаар үнэлэх

Хүснэгт 7

Балл	Үнэр	Үнэрийн шинж байдал
0	Ямар ч үнэргүй	Мэдэгдэхүйц амтгүй
1	Маш сул	Хэрэглэгчдэд үл мэдэгдэх, лабораторит мэдэгдэхүйц
2	Сул	Хэрэглэгчдэд үл мэдэгдэх ба хэлснээр мэдэж болох
3	Мэдэгдэхүйц	Эвгүй, амархан мэдэгдэхүйц амт
4	Хурц	Анхаарал татсан, уухад зохимжгүй
5	Маш хүчтэй	Ууж болохгүй, их амттай

Ундын ус ямарч амтгүй байх ёстой бөгөөд үнэр нь стандартад зааснаар 2 баллаас хэтрэх ёсгүй.

**Усны өнгө:**

Байгаль дээрх ус өнгөгүй байдаг. Ус өнгөтэй болох нь бохирдож, чанар нь муудаж байгааг илтгэнэ.

Усны өнгийг тодорхойлохдоо 14-16 мм-ийн голчтой өнгөгүй хуруу шилэнд 10-12 см өндөртэй байхаар хийж, цагаан дэвсгэр дээр дээрээс нь харж өнгийг тодорхойлно.

Өнгийг бүдэг тодоор нь өнгөгүй, үл мэдэг шаравтар /боровтор, ногоовтор/, шаравтар, шар, тод шар өнгөтэй гэх мэт тохирох өнгөөр ангилна.

**Усны тунгалагшил ба булингаршил**

Байгалийн ус ялангуяа урсгал ус ихэвчлэн булингартай байдаг. 14-15 мм голчтой, өнгөгүй хуруу шилэнд шинжилж буй уснаас 10-12 см өндөртэй байхаар хийгээд хар дэвсгэр дээр дээрээс нь харж тодорхойлно. Булингаршлыг тунгалаг, үл мэдэг булингартай, бүдгэвтэр, бага зэрэг булингартай, булингартай, их булингартай гэж хуваана.

## **2.12.ХАА-н үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулагдсан бусад газрын бохирдол**

Хот суурингийн хянан баталгаа хийх аргачлалтай адил байна. Харин эдгээр газарт газар шорооны ажил гүйцэтгэх явцад гарсан үржил шимт хөрсийг арилгаж, дараа нь тарааж байгалийн нөхцөлд нь ойртуулсан байх, мөн талбайг ургамлан нөмрөгтэй болгоход чиглэсэн арга хэмжээ авсан байна. Үүнийг хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын тусгаг бүрхэвчээр тодорхойлох ба хээрийн судалгаагаар хөрс, ургамлан нөмрөг, газрын төрх байдлын бичиглэл хийж тогтооно.

## **2.13.Зам, шугам сүлжээний газрын бохирдол**

Хот суурингийн хянан баталгаа хийх аргачлалтай адил байна. Зам шугам сүлжээний газрын 5-10 км тутамд ажиглалт хэмжилтийг давтан үйлдэх ба замын салаалалт, хөрсний эвдрэл, шавар шалбааг үүссэнийг газрын гадаргын өөрчлөлттэй холбож үзнэ.

## **2.14.Нийтийн эдэлбэрийн газрын бохирдол**

Хот суурингийн хянан баталгаа хийх аргатай адил байна.

## **2.15.Хээрийн ажлын тайлангийн агуулга**

- **Нүүр хуудас** нь хүрээтэй байх ба дотор нүүр хуудсанд хянан баталгаа гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн гүйцэтгэсэн ажилтнууд, захирал гарын үсэг зурж баталгаажуулан, тамга дарсан байна. (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /үсгийн хэмжээ 16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /үсгийн хэмжээ 12, томоор/)
- Гарчиг (хуудасны дугаартай байх)
- Ерөнхий мэдээлэл /хээрийн ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, гэрээний хугацаа, мөрдсөн заавар, аргачлал /хуулийн заалтууд бичихгүй/, хээрийн ажил гүйцэтгэсэн аймаг сумын нэр, хугацаа, багийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн оролцоо, орон нутгийн оролцсон байдал/
- Хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө, түүний гүйцэтгэлийн хувь, гүйцэтгэх хүмүүсийн нэр, ажил үүргийн хуваарь, хугацаа
- Хээрийн судалгааны маршрут, гүйцэтгэл, нэмэлт маршрут, эдгээрийн тайлбар
- Хээрийн ажилд ашигласан техник, багаж хэрэгсэл, ашигласан материалын жагсаалт
- Ажлын зургийн хуулбар, тайлбар, хээрийн нөхцөлд тодотгосон эсэх
- Хээрийн ажил гүйцэтгэхэд тулгарсан бдавсэрхшээл, түүнийг шийдвэрлэсэн байдал
- Хавсралт (Аймаг, сумд болон бусад байгууллагатай харьцсан албан бичгийн хуулбар, Мониторингийн болон бусад цэгийн солбицолын жагсаалт, бичиглэлийн хуулбар, фото зураг, цэгийн хувийн хэрэг, тайланд засвар гарсан бол засварын жагсаалт, түүнийг зассан тухай тайлбар (хүснэгт))

- Баталгааны хуудас

## **2.16.Хээрийн ажлын захиалагчийн хяналт**

Гүйцэтгэгч хээрийн ажлыг эхлэх, дуусгахдаа 7-оос доошгүй хоногийн өмнө захиалагчид мэдэгдэж, хээрийн ажлын тайланг ирүүлнэ.

Энэ нь хээрийн ажлын захиалагчийн хяналт хийх бэлтгэл ажлыг хангах, хээрийн ажлыг шалгах удирдамж боловсруулах, хүний нөөц, техникийн бэлэн байдлыг хангах зорилготой.

Захиалагчийн хяналт дараах байдлаар хийгдэнэ.

1. Аймгийн засаг даргын захирамжаар аймгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэргэжилтэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн, Сумын Засаг дарга, Газрын даамал, сумын мал үржлийн тасгийн дарга, мэргэжилтэн, сумын байгаль хамгаалагч гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулж, удирдамжийг батална. (Ажлын хэсэг гүйцэтгэгчийг хээрийн судалгаа хийх явцад хамтран явж хяналт хийж болно.)
2. Ажлын хэсэг хээрийн ажлыг газар дээр нь шалгаж, захиалагчийн хяналтын тайлан, дүгнэлтийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Тайланд ажлын хэсгийн бүрэлдэхүүн баталсан тушаал, удирдамжийн хуулбар, дутуу, зөрүүтэй хийгдсэн ажлын жагсаалт, нэмж хийх ажлын жагсаалт, сумын эрх бүхийн албан тушаалтнуудын оролцсон байдал зэргийг тусгасан байна.

Ажлын хэсгийн тайлан, дүгнэлт, мэргэжлийн хэлтсийн ажил шалгасан дүгнэлтийг үндэслэж хээрийн ажлын тайланг архивт хүлээн авна.

Мөн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас ажлын хэсэг байгуулж, удирдамжийн дагуу хээрийн ажлын гүйцэтгэлийг газар дээр нь түүвэрчлэн шалгана.

## **3.МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАЛТЫН АЖИЛ**

Материал боловсруулалтын ажлын хүрээнд бэлтгэл болон хээрийн судалгааны явцад бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэх, боловсруулалт хийх, дүн шинжилгээ хийх, зураглах ажил хийгдэнэ.

Тайлан боловсруулах ажил нь лабораторийн шинжилгээний дүгнэлтийг тайлбарлах, үндсэн мэдээллийг боловсруулах, дүгнэлт паспорт бичих, хавсралт хүснэгтийг боловсруулах, шаардлага бичих гэсэн хэсгээс бүрдэнэ.

### **3.1.Үндсэн үзүүлэлт**

Дараах үзүүлэлтүүдийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлох бөгөөд Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу итгэмжлэл авсан лабораторит хийлгэнэ. Үүнд:

#### **А.Хөрсний физик шинж чанарын шинжилгээ:**

1. Механик бүрэлдэхүүн
2. Ялзмаг
3. Хөрсний рН

#### **Б. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээ:**

1. Нянгийн тоо
2. Гэдэсний савханцарын таньц
3. Перпенгенсийн таньц

#### **В. Хөрсний хүнд металлын шинжилгээ:**

Хөрсний дээжинд ямар хүнд металлыг тодорхойлох нь тухайн хөрсний дээж авсан газрын бохирдлоос хамаарах тул элементийг тодорхой заагаагүй болно.

#### **Г. Усны шинжилгээ:**

- Усны ерөнхий шинж чанар
- Усны орчин рН
- Цахилгаан дамжуулах чанар
- Усны эрдэсжилт
- Усны хатуулаг

Шинжилгээний дүнг лабораторийн тамга, тэмдгээр баталгаажуулан, эх хувиар эцсийн тайланд хавсаргана.

### **3.2. Хянан баталгааны үндсэн мэдээллийг боловсруулах нь**

Үндсэн мэдээллийг хүснэгт хэлбэрээр боловсруулах ба хүснэгт тус бүрийг өмнө хийсэн хянан баталгааны ажлын үр дүнтэй харьцуулан тайлбарлаж тайланд оруулна. Хүснэгт болон тайланг заавал Agial фонд бичсэн байна.

Үндсэн мэдээлэлд дараах мэдээллүүд орно. Үүнд:

1. Хот суурин газрын хянан баталгааны үндсэн үзүүлэлт (дэд нэгж талбар бүрээр)
2. Хянан баталгааны үндсэн болон дэд нэгж талбарын тоо, газар ашиглалтын зориулалт, дэд нэгж талбарт хуваасан тайлбар
3. Дэд нэгж талбар бүрийн тодорхойлолт, дүгнэлт
4. Мониторингийн цэгийн хувийн хэрэг
5. Хөрсний физик, химийн үзүүлэлтийн шинжилгээний дүн
6. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн
7. Хөрсний хүнд металлын шинжилгээний дүн
8. Усны шинжилгээний дүн

Хот суурин газрын хянан баталгааны үндсэн үзүүлэлт нийт 10 үзүүлэлтээс бүрдэнэ. Хүснэгт бөглөх жишээг дор харуулав.

..... аймгийн (аймгийн код) ..... сум (сумын код)-ын хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дэлгэрэнгүй үзүүлэлт

Хүснэгт 8

№	Үндсэн нэгж талбарын дугаар	Дэд нэгж талбарын дугаар	Дэд нэгж талбарын талбайн хэмжээ, м <sup>2</sup> /га	Газар ашиглалт	Талбайн хэмжээ, м <sup>2</sup> /га	Үүнээс эвдэрч бохирдсон талбайн хэмжээ, м <sup>2</sup> /га			Мониторингийн цэгийн дугаар, солбицол
						Хэвийн	Физик бохирдол	Химийн бохирдол	
	01	0001	100						

..... аймгийн (аймгийн код) ..... сум (сумын код)-ын хот суурин газрын хөрсний механик бүрэлдэхүүний шинжилгээний дүн

Хүснэгт 9

Дэд нэгж талбарын дугаар	Цэгийн төрөл, дугаар	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, %, ширхэгийн хэмжээ, мм			Механик бүрэлдэхүүн	Ялзаг, %	РН
			Элс (2-0.05мм)	Тоос (0.05- 0.002мм)	Шаар (< 0.002мм)			
	Хяналтын цэг -1							

Тайлбар: Механик бүрэлдэхүүнийг 7 ангилж шинжилгээний дүн гарсан бол 7 задалж бичнэ.

Хөрсний бохирдлын шинжилгээний дүн  
Хүснэгт 10

Дэд нэгж талбарын дугаар	Цэгийн төрөл, дугаар	Дээж авсан гүн, см	Босго утга	Нянгийн тоо	Гэдэсний савханцарын таныц	Перфрингенсийн таныц	Хяналтын цэгийн дүн

Хөрсөн дэх зарим хүнд металлын шинжилгээний дүн

Хүснэгт 9

Дээж авсан гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг			
Дундаж хэмжээ				
Зөвшөөрөгдөх хэмжээ				
Хортой агууламж				
Аюултай агууламж				

**Тайлбар:** Хөрсний хүнд металлын бохирдол нь тухайн орчны газар ашиглалтын зориулалтаас хамаарах тул тодорхойлох хүнд металлыг тусгайлан зааж, лабораторын шинжилгээнд оруулна. Өөрөөр хэлбэр гэр хорооллын газарт автомашины утаа, нүүрсний утааны нөлөөгөөр хөрсний өнгөн гадарга хүнцэл буюу мешьяк, хар тугалга зэрэг элементээр бохирдох тул эдгээрийн хэмжээг тодорхойлох шинжилгээг хийлгэнэ гэсэн үг.

Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ MNS 5850:2008 стандартад заасны дагуу хүнд металлын шинжилгээний дүнг хөрсний механик бүрэлдэхүүнийг харгалзан зөвшөөрөгдөх, хортой, аюултай агууламжийг түүж бичнэ. Хүнд металлын нэрийг латин эхний 2 үсгээр болон монголоор бичнэ. Жишээ нь Pb /Хар тугалга/.

Ундны усны шинжилгээний дүн

Хүснэгт 10

№	Үнэр	Амт	Өнгө	Булингаршил	РН	Эрдэсжилт, г/дм <sup>3</sup>	Хатуулаг, мг-экв/дм <sup>3</sup>	Цэгийн солбицол

### **3.3.Өмнө хийсэн хянан баталгааны үр дүнтэй харьцуулах**

Өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах нь хянан баталгааны ажлын гол ач холбогдол оршино.

Өөрөөр хэлбэл бохирдсон газрын хэмжээ нэмэгдсэн эсэх, халцгай газрын хэмжээ нэмэгдсэн эсэх, хөрсний бохирдол ямар хэмжээнд хүрсэн эсэх зэргийг тодорхойлохоос гадна цаашид авах арга хэмжээ, хянан баталгааны акт бичих гол эх сурвалж болно.

Мөн одоогийн хянан баталгааны үзүүлэлтийг холбогдох стандарттай харьцуулж, бохирдлын зэрэглэлийг тодорхойлох нь маш чухал.

### **3.4.Мониторингийн цэгийн хувийн хэрэг бүрдүүлэх**

Хувийн хэргийг хавсралт 7-д заасны дагуу бүрдүүлж, тайланд хавсаргана.

### **3.5.Хянан баталгааны дүгнэлт бичих**

Хот суурингийн хянан баталгааны дүгнэлтийг дэд нэгж талбар бүрээр бичнэ.

Энэ дүгнэлт нь дэд нэгж талбарт байрлаж байгаа зам талбай, ногоон байгууламж, аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрийн газар, айл өрх, иргэдийн эзэмшил газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт болох тул нарийн, тодорхой бичих шаардлагатай. Ялангуяа бохирдол үүссэн, хөрсний элэгдэл эвдрэлд орсон газруудын тодорхойлолтыг дүгнэлтэд заавал тусгана.

Хэд хэдэн байгууллага нэг /барилгад/ объектод байрлаж байгаа бол тухайн барилгын ерөнхий түрээслүүлэгч байгууллагын нэрээр бичигдэнэ.

Хянан баталгааны дүгнэлтэд хэмжилт, задлан шинжилгээний дундажласан тоон утга, үнэлэлт дүгнэлт бичигдэх бөгөөд дэд нэгж талбарын зургийг хавсаргана.

Эзэмшил ашиглалтад олгогдоогүй газрын дүгнэлтийг бичихдээ тухайн газар дээр авсан хөрсний шинжилгээн үр дүнд тулгуурлана. Өөрөөр хэлбэл ашиглагдаагүй газрын хянан баталгааны дүгнэлт нь шинээр эзэмшил, ашиглалтад олгох болоход анхны хянан баталгааны дүгнэлт болох учир үүнийг сайн бичих шаардлагатай.

### **3.6.Хянан баталгааны акт бичих:**

Хянан баталгааны акт нь Газрын тухай хуулийн 50, 51-р заалтыг хэрэгжүүлэх, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлэх, газар зохион байгуулалтын арга хэмжээг тогтоож үүрэгжүүлэхэд чиглэнэ.

Хянан баталгааны актыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын инженер геологи, хот суурингийн газрын хянан баталгааны асуудал хариуцсан мэргэжилтэн сум бүрээр болон аймгийн хэмжээгээр гаргана.

Хээрийн ажиглалт хэмжилт, лабораторийн задлан шинжилгээний дүнг үндэслэн актыг гаргах бөгөөд дараах загварын дагуу гаргана.

... аймгийн ... сумын хот суурин газрын хянан баталгааны акт

Газрын нэр, нэгж талбар	Цаашид газар ашиглалтад тавигдах шаардлага	талбай, га

Актыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга буюу хянан баталгааны улсын ерөнхий шинжээч баталгаажуулан, тухайн орон нутгийн захиргаа болон Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүргүүлнэ.

Ялангуяа төлөв байдлын ба чанарын өөрчлөлт гарсан тохиолдолд ихээхэн анхаарал тавих хэрэгтэй. Өөрчлөлтийн үндэслэл ба зэрэглэл, шалтгаан, түүнд нөлөөлсөн хүчин зүйл, эерэг ба сөрөг талыг тодорхой баримт үндэстэй актад тусгана.

Мөн хээрийн ба материал боловсруулалтын хугацаанд ажиглагдаж байсан буюу тэмдэглэгдсэн хэдийгээр дүгнэлт гаргах үндэслэл болохооргүй ч гэсэн дараагийн хянан баталгааны ажилд мөн цаашдын газар ашиглалт, хамгаалалтанд анхаарах газрын төлөв байдал, чанарын онцлогийг тусгасан байна.

Акт хэдий чинээ дэлгэрэнгүй олон талаас нь авч үзсэн байх тутам төдий чинээ сайтар үндэслэлтэй болно. Хянан баталгааны дүгнэлтэд хавсаргах зураг ба шаардлагын бүрдэлтээр тухайн хянан баталгааны ажлын чанар тодорхойлогдоно. Өөрөөр хэлбэл хянан баталгааны дүгнэлт, зураг, акт нь хянан баталгааны нэгдсэн тодорхойлолт болно.

### 3.7. Нэгж талбарын сүлжээний зураг боловсруулах

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний тоон зураг боловсруулах ажил дараах хэсгээс бүрдэнэ. Мэдээлэл оруулахдаа заавал Agial фонд ашиглана.

1. Зураглах
2. Хүснэгтэн мэдээллийг оруулах
3. Зургийн эх бэлтгэх, хэвлэх

#### 3.7.1.Зураглах

1. Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний тоон зургийг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан WGS-84 солбицол, UTM тусгагт зураглана.
2. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас аймаг, сумын хилийг тоон хэлбэрээр авч ашиглах бөгөөд сумын төвийн тэг гортигийг тухайн сумын захиргаанд баримталж байгаа хилээр зураглана.
3. Цэг, шулуун, талбай хэлбэрээр зураглах ба эдгээр нь орон зайн мэдээллийн сангийн шаардлагыг хангасан хүснэгтэн мэдээллийн болон таних тэмдгийн загвартай байна.



4. Хянан баталгааны өгөгдлийн сангийн загварыг үндэсний орон зайн мэдээллийн санд нийцүүлэн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.
5. Тоон зургийн топологийн алдааг засварласан байна.

### 3.7.2. Хүснэгтэн мэдээлэл оруулах

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зургийн давхарга бүр хүснэгтэн мэдээлэлтэй байх бөгөөд хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны өгөгдлийн сангийн загварын дагуу оруулна. Хүснэгтэд мэдээллийг заавал Arial фондоор бичнэ.

1. Үндсэн нэгж талбар
2. Дэд нэгж талбар
3. Нийтийн эдэлбэрийн газар
4. Хатуу хучилттай газар
5. Ногоон байгууламж бүхий газар
6. Гэр хорооллын газар
7. Гудамжууд
8. Хогийн цэг, талбай
9. Мониторингийн цэг
10. Хөрсний дээж авсан цэг
11. Ургамлын бичглэл хийсэн цэг

Гүйцэтгэгч хянан баталгааны орон зайн мэдээллийг үндэсний орон зайн мэдээллийн санд оруулах бөгөөд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын орон зайн мэдээлэлийн асуудал хариуцсан нэгжээр дүгнэлт гаргуулж, эцсийн тайлангийн ард хавсаргана.

### 3.7.3. Зургийн эх бэлтгэх

Хил залгаа аймаг, сумдын нэгж талбарын сүлжээний зургийн хил зааг уялдаж байгаа /тохирч байгаа/ эсэхийг захиалагч буюу орон зайн мэдээлэл, технологийн болон мэргэжлийн хэлтэс хамтран шалгаж дүгнэлт гаргана.

Зургийн эх бэлтгэхдээ заавал текст, тоог Arial фондоор, тохирох үсгийн хэмжээгээр бичнэ. Жишээ нь:

- зургийн нэр 14 (үсгийн хэмжээ)
- булангийн хүснэгт 10-аас доош (үсгийн хэмжээ)
- зургийн тайлбар 12-оор (үсгийн хэмжээ)
- таних тэмдэг, нэгж талбарын дугаар, мониторингийн цэгийн дугаар тохирох хэмжээгээр (үсгийн хэмжээ) бичнэ.

Зургийн үндсэн өнгө нь үндсэн нэгж талбарын өнгө байх бөгөөд гэр хорооллыг цэнхэр өнгөөр, барилгажсан, хатуу хучилттай талбайг улбар шар өнгөөр хийнэ.

Зургийн нэрийг өгөхдөө Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн код, MNS5641-0-2006 2х, MNS5641-1-2006 6х, MNS5641-2-2006 34х, MNS5641-3-2006 47х стандартыг ашиглан аймаг, сумын кодыг бичнэ. Жишээ нь: *Архангай аймгийн (аймгийн код) Ихтамир сум (сумын код)-ын хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зураг*

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 52 дугаар тогтоолоор баталсан дараах стандартыг мөрдөнө.

- “Байр зүйн болон дэвсгэр зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:500, 1:1000, 1:2000, 1:5000. MNS 6702:2017”,
- “Байр зүйн зургийн загвар сан, таних тэмдэг. Масштаб: 1:25000, 1:50000, 1:100000. MNS 6703:2017”

### ЗУРАГТ НЭГЖ ТАЛБАРЫН ДУГААР БИЧИХ

Зурагт нэгж талбарын дугаарыг 001/120 гэж бичнэ. Энэ нь дэд нэгж талбарын дугаар, талбайн хэмжээг харуулсан байна.

Анхны хянан баталгааны нэгж талбарын дугаар өөрчлөгдөхгүй байна.

Харин шинэ дэд нэгж талбарыг хамгийн сүүлийн дэд нэгж талбарын дугаарлалтаас эхлэн дугаарлана.

Хэрэв дэд нэгж талбар хуваагдсан бол а, б гэж ялгах нэмэлт дугаар өгнө. Өөрөөр хэлбэл 00001a/60, 00001b/60 гэж дугаарлана.

Хэрэв өмнөх хянан баталгааны дэд нэгж талбарын дугаар өөр хэлбэрээр өгөгдсөн бол түүнийг олох хүснэгтийг тайланд тусгана. Жишээ нь:

Хүснэгт 11

№	Газрын нэр	Өмнөх нэгж талбарын дугаар	Одоо өгч байгаа нэгж талбарын дугаар
1	Нэмнэн	001/120	001a/60, 001b/60

### ЗУРАГТ ХҮРЭЭ ОРУУЛАХ

Нэгж талбарын сүлжээний зурагт газар зүйн солбицолын тор хийх бөгөөд зураас нь харагдахгүй байна.

### ЗУРАГТ ХҮСНЭГТ ОРУУЛАХ

Хянан баталгааны нэгж талбарын сүлжээний зурагт тусгагдсан үзүүлэлт болон тайлангийн дэлгэрэнгүй хүснэгтийн үзүүлэлт адил байна.

Хянан баталгааны зурагт мониторингийн, бичиглэл хийсэн, дээж авсан цэгийн мэдээллийг дараах хүснэгтээр оруулна.

## Мониторингийн цэгийн мэдээлэл

Хүснэгт 12

Нэгж талбарын дугаар	Талбайн хэмжээ, га	Мониторингийн цэгийн дугаар	Солбицол	Дээж авсан гүн	Хөрсний эрүүл ахуй бохирдол	Хөрсөн дэх хүнд металлын бохирдол

Нэгж талбарын зургийн баруун доод буланд зургийг хийсэн болон шалгасан мэдээллийг оруулна.

## Булангийн хүснэгт

Хүснэгт 13

Ажлын нэр: ... аймгийн ... сумын хот суурин газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа							
Захиалагч байгууллагын нэр: ГЗБГЗЗГ				Гүйцэтгэгч байгууллагын нэр/тамга: "Глобус" ХХК			
Шалгасан	Албан тушаал	Нэр	Гарын үсэг	Гүйцэтгэсэн	Албан тушаал	Нэр	Гарын үсэг
	<i>Хэлтсийн дарга</i>				<i>Захирал</i>		
	<i>Мэргэжилтэн</i>				<i>Зургийн боловсруулалт хийсэн</i>		
Архив, мэдээллийн төвд хүлээлгэн өгсөн огноо: 2018.03.25				Масштаб: 1:5000		Хэвлэсэн хувь: 3	

### 3.7.4. Зураг хэвлэх

Хот суурин газрын хянан баталгааны ажил 1 сум, суурин газрын хэмжээнд хийгддэг тул АЗ цаасан дээр нэг бүрчлэн хэвлэнэ. Харин нийслэл, томоохон хот, аймгийн төвүүдийн зургийг АЗ цаасан дээр хувааж хэвлэх тул дараах байдлаар хэвлэнэ.

1. Хянан баталгааны зургийг АЗ цаасанд багтааж хэвлэх (булангийн хүснэгттэй байх, бусад хүснэгт багтах боломжгүй бол оруулахгүй байх, энэ зургийн зүүн дээд буланд тухайн сум аймгийн аль хэсэгт байрласан тухай тойм зураг хийсэн байна)
2. Хянан баталгааны зургийг АЗ цаасанд (АЗ хэмжээгээр тор татсан, торны нүдийг дугаарласан) багтааж хэвлэх
3. Хянан баталгааны зургийг АЗ цаасанд багтаан (хуваасан тор бүрээр) 1:100000 масштабаар хэвлэх

Хэвлэсэн зургийг дэс дарааллын дагуу АЗ цаасны хэмжээтэй стандарт хайрцагт (архивын) хийж хүлээлгэн өгнө.

### 3.8. Хянан баталгааны ажлын тайлан

#### Тайлан бичих

Тайланг дор дурьдсан бүтцийн дагуу Arial фондоор, үсгийн 12 хэмжээтэй, мөр хоорондын зай 1.5-аар бичнэ.

Тайланг бичихдээ үг үсгийн алдаагүй, утга найруулга сайтай, 1 санааг олон давхардуулахгүй байхад анхаарна. Тооны орон таслалын ард 1 байхаар бичнэ.

Бусад эх сурвалжаас иш татсан бол өгүүлбэрийн ард дөрвөлжин хаалтанд дугаарыг (ашигласан материалын жагсаалтын дугаар) бичнэ.

- (Гадна нүүр хуудас (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /14, томоор/, УЛААНБААТАР, ...ОН /12, томоор/) Захиалагчийн нэр, ажлын нэрийн доор тухайн аймгийн сумын байршлыг харуулсан зургийг оруулж болох ба аймаг бүрийн тайланг өөр өнгийн хавтсанд хийнэ.
- (Дотор нүүр хуудас (ЗАХИАЛАГЧИЙН НЭР /үсгийн хэмжээ 12, томоор/, АЖЛЫН НЭР /16, томоор/, ГҮЙЦЭТГЭГЧИЙН НЭР /14, томоор/, оролцсон хүмүүсийн ажлын байрны нэр ба мэргэжилтэний нэр, гарын үсэг, УЛААНБААТАР, ...ОН /12, томоор/) Гарчиг (Хуудас бүр дугаартай байна)  
Зургийн жагсаалт (хуудасны дарааллаар)  
Хүснэгтийн жагсаалт (хуудасны дарааллаар)  
Графикийн жагсаалт (хуудасны дарааллаар)
- **Үндэслэл** (ажил гүйцэтгэх үндэслэл, ажлын зорилго, зорилт, гэрээний дугаар, гэрээний хугацаа, ашигласан журам, заавар, аргачлал /хуулийн болон журмын заалтууд бичихгүй/-ийн жагсаалт, хамтран ажилласан байгууллага, хүмүүс, тэдний гүйцэтгэсэн үүрэг, хээрийн судалгааны ажлын төлөвлөгөө, маршрут, гүйцэтгэл, гүйцэтгэсэн хүмүүс, ажил үүргийн хуваарь, гүйцэтгэсэн хугацаа, ашигласан техник, багаж хэрэгслийн жагсаалт, хуучин хянан баталгаа хийсэн талаарх мэдээлэл, товч үр дүн зэрэг мэдээллийг агуулна.)
- **Хянан баталгааны арга зүй** (арга зүйг схемээр харуулж тайлбарлах, цуглуулсан мэдээлэл, эх сурвалж, ажлын үе шат бүрт хийсэн ажлын жагсаалт, хиймэл дагуулын зураг боловсруулсан арга зүй, ажлын зураг, түүний бүрдэл, тэдгээрийн эх сурвалж)
- **Байгаль, нутаг дэвсгэрийн тухай мэдээлэл** (газар зүйн байршил, газрын гадарга, цаг уур, хөрсөн бүрхэвч, ургамалжилт)-ийг эх сурвалжийн хамт бичнэ. Суурин газрын байршлыг байр зүйн зураг, агаар сансрын зураг дээр болон гадаргын өндөржилтийг зургаар харуулна. Уур амьсгалын мэдээллийг хамгийн ойр байрлах станцын сүүлийн 5-аас доошгүй жилийн мэдээллийг ашиглан бичнэ. Хөрсний шинж чанар, ургамалжилтын мэдээллийг хамгийн сүүлийн үеийн эх сурвалж ашиглан бичнэ. Ном сурах бичиг, судлаачийн бүтээлээс ишлэл авсан тохиолдолд уг өгүүлбэрийн ард нь хаалтанд, бүтээл болон номны нэр, зохиогч, оныг дурьдаж ашигласан материалын жагсаалтад оруулна.)
- **Хот суурин газрын ашиглалтын өнөөгийн байдал** (сүүлийн 5 жилийн газрын нэгдмэл сангийн тайлан, газрын нэгдмэл сангийн тооллого, агаар, сансрын зураг, кадастрын зураг, 1:1000 масштабтай байр зүйн зургийг харьцуулах байдлаар суурин газрын талбайн хэмжээг тайлбарлан бичих, талбайн хэмжээ

нэмэгдсэн, хасагдсан шалтгааныг тодорхойлох, газар ашиглалтын төрлөөр ангилан талбайн хэмжээг гаргах, шинээр нэмэгдсэн газруудыг зургаар харуулах, автозам гарсан газрыг талбайгаар харуулах, хог хаягдлын цэгийн байршлыг харуулах, гуу жалга гарсан, хөрсний элэгдэл эвдрэлд орсон газрын хэмжээ, байршлыг харуулах, эдгээрийг фото зургаар харуулах, хөрс, ургамлын төлөв байдлыг фото зургаар харуулах, дэд нэгж талбар бүрийг фото зургаар (зураг авсан цэгийн солбицолыг оруулах, зураг авсан цэгүүдийг дугаарлах), бохирдсон (физик, хими, биологийн) газруудыг зургаар харуулах, худаг уст цэгүүдийг фото зургаар харуулах, зурагт эрүүл ахуйн бүсийг зурсан байх, малтай хороо, уурын зуухны орчим)

- **Хот суурин газрын төлөв байдал, чанарын өөрчлөлт** (хээрийн судалгаа хийсэн цэгүүд, тэдгээрийг ямар үндэслэлээр авсан тухай, хөрсний дээж авсан гүн, хэмжээ, цэгийн байршлыг зургаар харуулах, цэгүүдийг дугаарлах, лабораторын шинжилгээний дүнд тулгуурлан хөрс, ургамлын шинж чанарын өөрчлөлт, хөрсний хүнд металлын болон эрүүл ахуйн шинжилгээний үр дүнг өмнөх хянан баталгааны үр дүнтэй харьцуулах, үнэлэлт дүгнэлт өгч тайлбарлах (фото зургаар, графикаар)
- **Мониторингийн цэгийн мэдээлэл** (Дэд нэгж талбарын дугаар, цэгийн дугаар, солбицол, үндэслэл (цэг байгуулсан үндэслэлийг цэг бүрээр тайлбарлах), зураг дээр цэгийн байршлыг харуулах, хөрс, ургамлын бичиглэл, фото зураг, лабораторын шинжилгээний дүнг тайлбарлах байдлаар оруулна. Хөрс, ургамлын бичиглэл, дүгнэлтийг тайлангийн хавсралтад оруулна.)
- **Хот суурин газрыг зохистой ашиглах, хамгаалах шаардлага** (хянан баталгааны ажлын үр дүнд үндэслэн хот суурин газрын ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийг газар ашиглалтын онцлог, өөрчлөлтийн чиг хандлагатай уялдуулан бичнэ. Зарим нэгж талбарыг тусгайлан арга хэмжээг зөвлөнө. Актыг сум бүрт адил бичихгүй байхад анхаарна.)
- **Дүгнэлт** (энэ дүгнэлт нь тайлангийн дүгнэлт бөгөөд сумын хэмжээнд нийт бэлчээрийн хэмжээ, хэдэн нэгж талбарт, хичнээн га талбайд хуваагдсан эсэх, ерөнхий ургамалжилт, байгаль газар зүйн онцлог, төлөв байдлын өөрчлөлтийн шалтгаан, өмнөх хянан баталгааны үр дүнгээс ямар байдлаар зөрсөн, түүний шалтгааныг тайлбарлах, үндсэн болон тусгай шаардлагыг тайлбарлах, хэрэгжүүлэх зөвлөмжийг товч дурьдсан байна. Дүгнэлт нь тайланд дурьдсан тоон утгаар баталгаажсан байдлаар бичигдсэн байна.)
- **Ашигласан материалын жагсаалт** /цагаан толгойн дарааллаар/, эх сурвалжийн нэр, он, хуудсын дугаар, хэвлэгдсэн газрын нэр, цахим хаяг
- **Хавсралт** (албан тоотын хуулбар, бэлтгэл, хээрийн ажлын дүгнэлт, акт, лабораторын шинжилгээний баталгаажуулсан дүн, паспорт буюу газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны дүгнэлт, мониторингийн цэгийн хувийн хэрэг, бичиглэл, дээж авсан цэгүүдийн мэдээлэл)
- Баталгааны хуудас

Газрын кадастрын мэдээллийн сан үнэн хэрэгтээ хянан баталгааны материалыг нэгтгэн дүгнэсний үр дүнд бий болно. Энэ утгаар л материалыг нэгтгэн боловсруулан баталгаажуулна.

Хээрийн ажлын тэмдэглэл ажиглалт, хэмжилтийн анхдагч материал, талбайд ашигласан, дээж авсан, хэмжилт хийсэн, цэг тэмдэглэсэн, мөн түүнчлэн аливаа өөрчлөлтийг тусгасан ажлын зураг зэргийг хүлээлгэн өгнө.

### Тоон файлыг хуулбарлах

Тоон зураг, тайлан, хавсралтыг 3 хувь CD-д хуулбарлана. CD-ний нүүрийг доорх загвараар хийх бөгөөд 1 сумын материалыг (фолдерийн нэр: *Argalant sum*) 1 фолдер үүсгэн, дараах фолдерыг энэ дэс дарааллын дагуу хадгална.

#### А. Зураг

1. Нэгж талбарын сүлжээний зураг, "jpg", 1:100000 масштабаар (файлын нэр: *Argalant\_jpg*)
2. Хуваалга хийсэн схем зураг, "jpg", А3 цаасны хэмжээгээр (файлын нэр: *Argalant\_scheme*)
3. Хувааж хэвлэсэн зураг, "jpg", А3 цаасны хэмжээгээр (файлын нэр: *Argalant\_jpg1*)



#### Б.Тайлан

4. Үндсэн тайлан, Arial фонт, "doc", "pdf" (файлын нэр: *Argalant\_tailan*)
5. Нэгдсэн хүснэгт, "exc" (файлын нэр: *Argalant\_husnegt1*)
6. Нөлөөллийн товчоо, "exc" (файлын нэр: *Argalant\_husnegt2*)
7. Дүгнэлт, паспорт (файлын нэр: T2116000467)

#### В.Хавсралт материал

8. Дараах мэдээллийг нэгж талбарын дугаараар 1 фолдерт хийнэ. Үүнд:
  - Хээрийн судалгааны фото зураг, "jpg", (файлын нэр: *Heer\_photo*)
  - Скайнердсан ургамлын бичиглэл, "pdf" (файлын нэр: *urgam\_bichiglel*)
  - Скайнердсан хөрсний бичиглэл, "pdf" (файлын нэр: *hurs\_bichiglel*)
  - Скайнердсан лабораторын шинжилгээний дүн, "pdf", (файлын нэр: T2116000467)
9. Боловсруулалт хийсэн агаар, сансрын зураг (фолдерийн нэр: *Argalant\_хиймэл дагуулын нэр*)
10. Arc GIS ажлын файл (фолдерийн нэр: *Argalant\_mxd*)
11. "gdb" өргөтгөлтэй дата бааз (фолдерийн нэр: *Argalant\_gdb*)

12. Топологи файл (фолдерийн нэр: *Argalant\_top*)

13. Байрзүйн элемент (фолдерийн нэр: *Argalant\_topo*, файлын нэр: *Argalant\_sum\_top, davaa, ovoo, ....*)

Файлыг дээрх дэс дарааллаар дугаарлан эрэмбэлж, сум тус бүрээр (цагаан толгойн дарааллаар) фолдер үүсгэн, CD/DVD-д хуулбарласан байна. Хэрэв дарааллын дагуу эрэмбэлж, хуулаагүй бол буцаана. CD/DVD-ний нүүрэнд гүйцэтгэгч байгууллага тамга дарсан байна.

### **3.9. Ажлын үр дүнг шалгах, хүлээн авах**

1. Ажлын үр дүнг шалгах, хүлээн авахад ГХГЗЗГ-ын даргын 2015 оны А/208 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих, үр дүнг үнэлэх, шалгаж хүлээн авах журам”-ыг мөрдөнө.
2. Ажлын үр дүнг хөндлөнгийн шинжээч томилох, түүвэрчлэн шалгах гэсэн 2 хэлбэрээр шалгаж болно.
3. Тухайн жилийн 10 сарын 1-ний өдрөөс өмнө ажлын эцсийн тайланг хүлээлгэж өгөх ба мэргэжлийн хэлтэс 11 сарын 15 гэхэд ажил шалгаж хүлээн авсан дүгнэлтийг гаргасан байна. Хэрэв засвар гарсан бол тухайн зөрчил арилсаны дараа ажил шалгасан дүгнэлтийг гаргана.
4. Бүх засвар хийгдсэний дараа гүйцэтгэгч ажлаа танилцуулга /presentation/ хэлбэрээр 10-15 мин багтаан захиалагчид танилцуулна. Энэ нь 1 багцын хэмжээнд байна.

Танилцуулгын зорилго нь бусад хийсэн ажилтай харьцуулах, сайн болон дутагдалтай талыг харах, ажлын үр дүнг нэгдсэн байдлаар үнэлэхэд чиглэнэ.

Танилцуулганд ажлын зураг, тухайн ажлыг хийсэн арга зүй, хээрийн ажлын маршрут, сансрын зураг боловсруулсан арга зүй, ашигласан материал, хээрийн судалгаанд оролцсон бүрэлдэхүүн, урьд нь хийсэн хянан баталгааны зураг, одоо хийсэн зураг, тэдгээрийн харьцуулалт, дэлгэрэнгүй үзүүлэлт, мониторингийн, бичиглэлийн цэгийн мэдээлэл, нөлөөллийн үзүүлэлт, дүгнэлт, зөвлөмжийг танилцуулна.

5. Ажлыг дутуу хийсэн, чанарын болон бусад доголдол, зөрчил гаргасан тохиолдолд ажил гүйцэтгэх гэрээнд заасны дагуу хариуцлага тооцно.
6. Ажлыг хүлээн авсны дараа Даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, 1 хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивт, 1 хувийг орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, 1 хувийг сумын Газрын даамлын ажлын хэрэгцээнд шилжүүлнэ.

оОо

## Монгол орны бэлчээр хадлангийн ангилаа ба өнгөний код

Зураг дээрхи индекс	Ангилалын шифр	Бэлчээр хадлангийн анги, бүлэг, төрөл, төрлүүдийн нэр	Өнгөний код, GIS-RGB
0	1	2	3
	Ө	<b>Өндөр уулын бэлчээр</b>	
	Ө-I	<b>Анги:Уулын царамын ширэгт ялзмагт, хүлэрхэг хөрстэй царам</b>	
	Ө-I-1	Бүлэг төрөл:Хаг-Хөвдөд царам	
1	Ө-I-1-1	Хагт, Хаг-хөвдөт	190-230-255
2	Ө-I-1-2	Боролжтой Зожир өвс-бушилзат, Зожир өвс-хагт	210-220-255
3	Ө-I-1-3	Боролжтой, хөвдөт болон Хөвд-улалжит	190-210-255
	Ө-II	<b>Анги:Уулын царамын хүлрэнцэр ялзмагт, өндөр уулын нугын хар шороорхуу харстэй өндөр уулын нуга</b>	
	Ө-II-1	Бүлэг төрөл:Дэгнүүлт үетэнт	
4	Ө-II-1-1	Бушилз-улалжит, Улалж-бушилзат	110-180-255
5	Ө-II-1-2	Бушилзат	0-170-230
6	Ө-II-1-3	Бушилз-жигжиг дэннүүлт үетэнт, Жигжиг дэгнүүлт үетэн-бушилзат	0-170-255
	Ө-II-2	Бүлэг төрөл:Сөөгт	
7	Ө-II-2-1	Боролжит болон Сөөгт	0-170-200
	Ө-III	<b>Анги: Өндөр уулын нугат хээрийн болон бүдүүн ялзмагт хөрстэй хээр</b>	
	Ө-III-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
8	Ө-III-1-1	Ботууль-бушилж-улалжит	0-130-170
9	Ө-III-1-2	Жигжиг дэгнүүлт үетэн-алаг өвс-бушилзат	0-210-255
	Ө-IV	<b>Анги: Өндөр уулын сул хөгжилтэй бүдүүн ялзмагт хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг хээр</b>	
	Ө-IV-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
10	Ө-IV-1-1	Жигжиг дэгнүүлт үетэн-бушилзат	80-210-255
11	Ө-IV-1-2	Жигжиг дэгнүүлт үетэн-алаг өвс-агьт	120-180-255
	У	<b>Дундаж өндөр болон нам, бэсрэг уулын бэлчээр</b>	
	У-II	<b>Анги: Уулын хар хүрэн ба нугын улирлын цэвдэгт хар шороон хөрстэй нугархаг хээр</b>	
	У-II-1	Бүлэг төрөл:Үндэслэг ишт үетэн	
12	У-II-1-1	Хиаг-алаг өвст	140-200-100
	У-II-2	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
13	У-II-2-1	Бутнуур-улалж-алаг өвст	140-210-100
14	У-II-2-2	Ботууль-алаг өвст-улалжит	80-255-120
15	У-II-2-3	Ботууль-зүр өвст	0-255-120



16	У-II-2-4	Биелэг-алаг өвст	150-255-120
17	У-II-2-5	Үетэн-улаан толгой-улалжит	0-140-0
18	У-II-2-6	Үетэн-алаг өвст	40-140-0
19	У-II-2-7	Жижиг дэгнүүлт үетэн-бутнуур-алаг өвст	80-140-0
20	У-II-2-8	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	0-190-10
21	У-II-2-9	Хялгана-зүр өвст	0-160-0
22	У-II-2-10	Хялгана-алаг өвст	0-160-40
	У-II-3	Үетэн-алаг өвст	
23	У-II-3-1	Жижиг дэгнүүлт үетэн-бутнуур-алаг өвст	0-255-80
24	У-II-3-2	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	80-160-0
25	У-II-3-3	Хялгана-зүр өвст	80-160-4
26	У-II-3-4	Хялгана-алаг өвст	80-160-80
	У-II-4	Бүлэг төрөл:Сөөгт	
27	У-II-4-1	Сөөгөн ширэнгэт	0-180-0
	<b>У-III</b>	<b>Анги: Уулын сул хөгжилтэй хар хүрэн ба хар шороон хөрстэй нугархаг хээрийн сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээр</b>	
	У-III-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
28	У-III-1-1	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	40-180-60
29	У-III-1-2	Ботууль-алаг өвст	80-180-0
	У-III-2	Бүлэг төрөл:Алаг өвст	
30	У-III-2-1	Сөөг бүхий Алаг өвс-үетэнт	120-180-0
	<b>У-IV</b>	<b>Анги:Уулын хүрэн заримдаа хар хүрэн хөрстэй хуурай хээрийн бэлчээр</b>	
	У-IV-1	Бүлэг төрөл: Үндэслэг ишт үетэнт	
31	У-IV-1-1	Хиаг-үетэн-алаг өвст	0-180-40
	У-IV-2	Бүлэг төрөл:Дэгнүүлт үетэнт	
32	У-III-2-1	Ботууль-алаг өвст	0-180-60
33	У-III-2-2	Ботууль-хялганат	0-200-0
34	У-III-2-3	Дааган сүүл-алаг өвст	80-200-0
35	У-III-2-4	Биелэг-алаг өвст	100-200-0
36	У-III-2-5	Хялгана, Хялгана-алаг өвст	150-200-0
37	У-III-2-6	Хялгана-зүр өвст	0-200-40
38	У-III-2-7	Хялгана-хиагт	0-220-0
39	У-III-2-8	Хялгана-үетэнт	80-220-0
40	У-III-2-9	Хялгана-хазаар өвст	0-220-60
41	У-III-2-10	Хялгана-харганат	140-220-0
42	У-III-2-11	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвст	140-220-50
43	У-III-2-12	Жижиг дэгнүүлт үетэн-хялганат	140-220-100
44	У-III-2-13	Үетэн-алаг өвст	180-220-40
45	У-III-2-14	Хазаар өвс-хялганат	0-255-0
46	У-III-2-15	Хазаар өвс-үетэнт	0-255-70
	У-IV-3	Бүлэг төрөл:Сөөгт	

47	У-IV-3-1	Харгана-үетэнт, Үетэн-харганат	80-255-0
	<b>У-V</b>	<b>Анги: Уулын сул хөгжилтэй хүрэн, цайвар хүрэн хөрстэй сийрэг ургамлтай чулуурхаг хээр</b>	
	У-V-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
48	У-V-1-1	Ботууль-алаг өвс-агьт	80-255-70
49	У-V-1-2	Жижиг дэгнүүлт үетэн-алаг өвс-агьт	140-255-0
50	У-V-1-3	Хялгана-алаг өвст	100-255-100
51	У-V-1-4	Хялгана-агьт	100-255-0
52	У-V-1-5	Хялгана-ерхөгт	100-255-80
53	У-V-1-6	Ерхөг-хялгана-агьт	140-255-0
54	У-V-1-7	Үетэн-хялганат	140-255-140
55	У-V-1-8	Үетэн-агь-шавагт	180-255-60
	У-V-2	Бүлэг төрөл: Алаг өвст	
56	У-V-2-1	Алаг өвс-агь-үетэнт	0-255-60
	У-V-3	Бүлэг төрөл: Сөөгт	
57	У-V-3-1	Харгана-үетэнт	180-255-140
	<b>У-VI</b>	<b>Анги: Уулын цайвар хүрэн ба бор хөрстэй цөлөрхөг хээр</b>	
	У-VI-1	Бүлэг төрөл: Дэгнүүлт үетэнт	
58	У-VI-1-1	Монгол өвс-ерхөгт	100-60-0
59	У-VI-1-2	Монгол өвс-хазаар өвст, Хазаар өвс-монгол өвс	100-60-30
